

АЛСЫН ХАРАА  
**2050**

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**ЗАСАГЛАЛ**

5

...ОНОДОР  
— Монгол Улс —



# АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ  
**ХӨГЖЛИЙН БОДЛОГО**



ЗАСАГЛАЛ

5

Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтох,  
захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин,  
цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж,  
төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн гурван талт хамтын ажиллагаа бүх хүрээнд  
өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн,  
авлигагүй улс болно.



## ЗАСАГЛАЛ

**Ерөнхий редактор:**

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН  
Баянгэрэлийн БАТБААТАР

**Редакцын баг:**

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН  
Бат-Амгалангийн БОЛДБААТАР  
Сундуйн СОДБААТАР  
Өлзийбүрэнгийн ЖАМЬЯН  
Ганбаатарын ОТГОНЖАРГАЛ

**Зөвлөх:**

Саркытын ЗУЛПХАР  
Мандахын БАЯНМӨНХ  
Цагаачийн ЭНХМАНДАХ

Жамбалын ЖАРГАЛ

Бямбажавын ГАНБАТ

**Дизайнер:**

Нямжавын БЯМБАЦОГТ  
Жаргалсайханы МӨНХСАЙХАН

**Гэрэл зураг:**

МРА.МН  
Жамбалын БАТБААТАР /БАКУ/  
Хишигтогтохын ТУШИГ

**Хавтасны зураг:**

Батбаатарын ЦОЛМОНБАЯР

Улаанбаатар хот 2022 он

Copyright © ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан болно. Бүтээлийг ашгийн бус зорилгоор олон нийтэд түгээх, хуваалцах, ашиглах, хэрэглэх эрхтэй бөгөөд гагцхүү эх сурвалжийг дурдана уу.

Хэвлэлийн эхийг Нэцко хэвлэлийн газарт бэлтгэж,  
"Мөнхийн үсэг" ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN: 978-9919-511-63-0



## ГАРЧИГ

ҮНДСЭН ХУУЛЬ БА ЗАСАГЛАЛ	8
УХААЛАГ ЗАСАГЛАЛ	14
УХААЛАГ БҮТЭЦ	26
ЦАХИМ МОНГОЛ	34
ЧАДВАРЛАГ, ЁС ЗҮЙТЭЙ МЭРГЭШСЭН ТӨРИЙН АЛБА	42
ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН НИЙГЭМ	50
АВЛИГАГҮЙ ЗАСАГЛАЛ	58

## ЗАСАГЛАЛ

Монгол Улс ардчилсан тогтолцоот нийгэмд шилжсэнээс хойш 30 гаруй жил болжээ. 1990 оны долоодугаар сарын 29-ний өдөр анхны, чөлөөт, олон намын оролцоотой, ардчилсан сонгууль явагдаж, Ардын их хурлын төлөөлөгчдийг чөлөөтэй сонгосон билээ.

Улс орны хөгжлийн үзэл баримтлал, арга замыг тодорхойлж, чиглүүлэн зохицуулах гол институт нь төр бөгөөд төрийн бодлого, үйл ажиллагаа нь хөгжлийг сааруулах, гацаах бус харин дэмжих, таатай нөхцөл бүрдүүлэх, үр дүнтэй, үр нөлөөтэй зохион байгуулахад чиглэх учиртай. Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа тогтвортой, ил тод, хариуцлагатай, хяналттай байх нь бусад салбарын бодлого, үйл ажиллагаанд эзргээр нөлөөлж, нийгмийн бүхий л хүрээнд тогтвортой байдлыг үүсгэж, улмаар хөгжилд хөтөлдөг.

2018 онд Дэлхийн банкны засаглалын судалгаагаар Монгол Улсын Засгийн газрын үр нөлөөг тодорхойлох үзүүлэлтээр 192 улсаас 103 дугаарт, зохицуулалтын чадварыг тодорхойлох үзүүлэлтээр 83 дугаарт, хуулийн засаглалын үзүүлэлтээр 103 дугаарт эрэмбэлэгджээ.

Энэ нь төрийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт хангалтгүй, төрийн үйлчилгээ иргэдийн хүсэн хүлээсэн шаардлагыг бүрэн хангахгүй байгааг илтгэнэ. Нөгөө талаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж тааруу, уян хатан бус байгаагаас иргэд, хувийн хэвшлийг дэмжсэн төрийн бодлого, зохицуулалтын үр дүн, үр нөлөө суларч байна. Төрийн захиргааны байгууллагууд чиг үүргийн давхардал, хийдэл их, бүтэц, зохион байгуулалт нь оновчтой биш, сонгууль бүрийн дараа өөрчлөгдөх хандлагатай болсон.

Шүүгч болон хууль хяналтын байгууллага нь хариуцлага хүлээх эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, шүүгчид мэргэжлийн болон ёс зүйн хариуцлага тооцох механизмын үр нөлөө суларсан. Үүний улмаас иргэдийн шүүх, хууль хяналтын байгууллагад итгэх итгэл суларч, шүүх засаглалын хараат бус байдлыг алдагдуулахад нөлөөлж байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын гэмт хэрэг нэмэгдэх хандлагатай болжээ. Үндсэндээ авлига, ашиг сонирхлын зөрчил газар авч энэ нь нийгэм, эдийн засгийн хөгжил, улс төрийн шинэчлэлд чөдөр тушаа болсоор байна.

Иймд цаашид засаглал хуваах зарчмыг хангаж, хяналт-тэнцвэрийг оновчтой болгож, төрийн хүнд суртал, данхар бүтэц, авлига хээл хахуулийн ужиг сүлжээг тасалж, иргэн төвтэй төр, нийгмийн шинэчлэлийг эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүний эхлэл нь Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлт ба Монголын ардчиллыг хамгаалан хөгжүүлэх, авлигаас ангид, хүнд сурталгүй, иргэн төвтэй, хуулийн засаглалыг бүтээхэд чиглэсэн бодлогын зорилго юм.

ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТОЙМ

# ҮНДСЭН ХУУЛЬ БА ЗАСАГЛАЛ


Олон улсад засаглалыг төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хоорондын харилцаагаар дамжуулан улс орон өөрийн нийгэм, улс төр, эдийн засгийн харилцаагаа зохицуулах эрхэмлэх зүйлс, бодлого, институцийн тогтолцоо хэмээн тодорхойлжээ.

Манай улс 1992 оны шинэ Үндсэн хуулиар тунхагласан эрх мэдлийн хуваарилалтын сонгодог зарчмыг хэрэгжүүлэхээр зорьж ирлээ. Аливаа үндсэн хуулийн гүйцэтгэх үүргүүдийн нэг нь засаглалын институцийг тодорхойлох явдал бөгөөд төрийн эрх мэдлийг хэн, ямар зорилгоор хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлоход оршдог. Ардчилсан тогтолцоонд иргэд өөрсдийгөө эрх мэдлийн тулгуур эх сурвалж бөгөөд үндсэн хууль нь иргэдийн сайн сайхны төлөө төрийн эрх мэдлийг хязгаарлах нийгмийн гэрээг өөртөө агуулж байdag гэж үздэг. Энэхүү эрх мэдлийг хязгаарлах үзэл санааг “Үндсэн хуулт ёс” гэж томьёолдог.

Засаглалыг ерөнхийлөгчийн, парламентын болон хоёулангийнх нь онцлог шинжийг агуулсан холимог тогтолцоо гэсэн гурван ангилалд хуваадаг. Монгол Улс парламентын засаглалтай бөгөөд засаглалын энэхүү хэлбэрийг хэвээр хадгалах нь чухал болохыг судлаачид онцолдог.

Улсын Их Хурал нь бүх ард түмнээс сонгогдох, тэдний хүсэл зориг, ашиг сонирхлыг бүрэн илэрхийлдэг, хууль тогтоох бүрэн эрхийг дангаар хэрэгжүүлдэг, байнгын үйл ажиллагаатай байгууллага билээ. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, шүүх эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг хангахад чиглэсэн зохицуулалтыг Үндсэн хуулиар тодорхойлсон.

Сонгогчдынхоо өмнө хариуцлага хүлээдэг болох нь ардчилсан засаглалын суурь зарчим бөгөөд татвар төлөгчдийн мөнгийг зохистой, хуулийн дагуу, үр дүнтэй, үр ашигтай төлөвлөн төсвөө баталж байгааг мэдэх эрх олон нийтэд байх нь чухал билээ. Иймээс парламентын үйл ажиллагаанд дотоодын болон олон нийтийн шууд хяналт бүхий тогтолцоог бий болгож хөгжүүлэх



Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг



нь ач холбогдолтой. Судалгаанаас харагад УИХ-д хяналт тавих хүрээ хязгаарлагдмал байгаа нь харагдаж байна. УИХ нь төрийн байгууллын тогтолцоонд өргөн эрх мэдэлтэй байгаагаас гадна нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар УИХ өөрөө тарахаас бусдаар түүнийг тараах боломжгүй. Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцсөний үндсэн дээр, эсхүл Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг 45 хоногийн дотор томилж чадахгүй тохиолдолд л УИХ тарах хуулийн зохицуулалттай.

Тухайн институцийн эрх мэдэл хэдий чинээ их байна түүнд орох гэсэн өрсөлдөөн төдий чинээ их байдаг. Монгол Улсад улс төрийн намууд эрх мэдлийн төлөө өрсөлдөхөөс илүү бодлогын асуудалд анхаарах нь чухал. Намууд ялгаатай байр суурьтай асуудлаар жинхэнэ бодлогоо уралдуулах, бодлогын нам байхыг чухалчилж, иргэд сонгогчдын улс төрийн хүсэл зоригийг бодлогодоо тусгах механизмыг бүрдүүлэх учиртай. Иймээс улс төрийн үйл ажиллагаа болох намын гишүүнчлэл, санхүүжилтэд олон нийтийн шууд хяналтаас өөр хяналтын тогтолцооны хувилбарыг бий болгох шаардлагатай. Улс төрийн үйл ажиллагаа зарим тохиолдолд далд явагддаг тул санхүүжилтийн ил тод байдлыг бүрэн хангахад бэрхшээлтэй байна. Үүний түгээмэл нэг механизм нь улс төрийн намын санхүүжилтийг хуульчлах, ил тод болгох явдал юм.

#### Ардчилсан үндсэн хууль

1992 онд баталсан Үндсэн хуульд "Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна" хэмээн заасан.

**Үндсэн хууль**

Үндсэн хууль бол "Алганд багтсан" Монгол Улс юм.  
Б.Чимид



Хууль тогтоогчид, төрийн өндөр албан тушаалтан болон шүүгчид ажил үүргээ гүйцэтгэхдээ тодорхой хэмжээний халдашгүй байдал эдлэх нь зүй ёсны асуудал гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Халдашгүй байдал нь иргэдээс сонгогдсон төлөөлөгчид хууль тогтоох байгууллагад эрүүгийн болон иргэний хуулийн дагуу хариуцлага хүлээх эрсдэлгүйгээр чөлөөтэй үг хэлэх, нэр төрийг нь аливаа гүжир гүтгэлгээс хамгаалах, тохиолдлын байдлаар албадан саатуулах, цагдан хорих, тэдний хувьд улс төрийн сэдэлтэй мөрдөх ажиллагаа явуулахаас сэргийлэх зорилготой байдаг.

Хуулийн ийм хамгаалалт нь төрийн өндөр албан тушаалтнуудад давуу байдал олгосон хэрэг бус харин тэдэнд албан үүргээ саадгүй гүйцэтгэх таатай нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ юм. Улс төрчдийн халдашгүй байдал нь хуулиас дээгүүр, аль эсхүл хууль үйлчилдэггүй хүмүүсийн давхарга үүсгэх бус, зөвхөн ардчилсан тогтолцоог хамгаалах зорилготой билээ.

Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаанд хутгалдан орохгүйгээр хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих арга ажиллагааг эрчимжүүлэх нь чухал. Ингэснээр парламентаас баталсан хууль тогтоомжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж, хариуцлагыг сайжруулахаас гадна хэрэгжилтийн явцад олж авсан мэдээлэл, тогтоогдсон нөхцөл байдалд тулгуурлан хууль тогтоомжийг илүү боловсронгуй болгож, сайжруулах боломжтой болно.

Монгол Улс парламентын засаглалтай учир гүйцэтгэх эрх мэдлийг тэргүүлж буй Ерөнхий сайд улс төрд жин дарах учиртай. Үндсэн хуульд Засгийн газрын бүрэн эрхийн хугацааг дөрвөн жилээр тогтоосон. 1992 оноос хойш ихэнх Засгийн газрууд бүрэн эрхийн хугацаанаасаа өмнө огцорч байжээ. Нэг парламентын

Ардчилсан ёс, шударга ёс,  
эрх чөлөө, тэгш байдал,  
үндэсний эв нэгдлийг  
хангах, хууль дээдлэх нь  
төрийн үйл ажиллагааны  
үндсэн зарчим мөн.

Монгол Улсын  
Үндсэн хуулийн 1 дүгээр  
зүйлийн 2 дахь хэсэг



Зураг 1. Төрийн  
эрх мэдлийн  
хуваарилалтын  
зарчим



Манай Үндсэн хуульд төрийн эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үзэл санаа тодорхой биежсэн. Төрийн чиг үүрэг тодорхой нэг институц дээр давуу байдлаар төвлөрөх ёсгүй. Төрийн эрх мэдлийг “хууль тогтоох”, “гүйцэтгэх”, “шүүх” гэж хуваарилахдаа тэнцвэрийг хангахаас гадна харилцан хяналт тавих зарчмыг үндэс болгосон. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ч энэ үзэл санаа улам батажсан.

бүрэн эрхийн хугацаанд дөрвөн Засгийн газар солигдож байсан тохиолдол гарч байв. Төрийн захиргааны төв байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт Засгийн газар солигдохтой хамт байнга өөрчлөгдөж ирсэн. Яамдыг салгах, нийлүүлэх, шинээр байгуулах, татан буулгах, нэршилийг нь солих, агентлагийн харьяаллыг өөрчлөх нь аль ч Засгийн газрын үед түгээмэл байсаар ирсэн. Үүнийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттой уялдуулж байна хэмээн тайлбарладаг. Гэхдээ уг өөрчлөлтийг хийхдээ өдийн засгийн тооцоо судалгаа, чиг үүргийн шинжилгээ хийх, салбар дундын зохицуулалтыг хангах, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагуудын санал авах, төсвийн ачааллыг багасгах гэх мэт тодорхой үндэслэлийг тооцох шаардлагатай. Зарим тохиолдолд яамдын тоог нэмэгдүүлэх нь сонгуульд ялсан болон эвсэлд нэгдсэн намын гишүүд, дэмжигчдийг сайдын албан тушаалтай болгоход чиглэгддэг гэсэн шүүмжлэлд өртөж байв. Иймд Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны тогтвортой, залгамж чанартай, үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд зорилго, зорилтуудаа чиглүүлсэн юм.

Шүүхийн хараат бус байдал дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.  
Үүнд:

- 1) шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй ижил эрх зүйн байдалтай төрийн бие даасан эрх мэдэл;
- 2) хараат бус байдлаа хадгалахын тулд шүүх нь бодлогоо өөрөө тодорхойлно;
- 3) шүүхийн төсвийг өөрсдөө боловсруулж, батлуулахаар парламентад оруулна;
- 4) шүүгч нарыг томилох буюу сонгох, дэвшүүлэх журам нь ил тод, тодорхой байх;

“  
Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан энэхүү эрхээ өдэлнэ.

Монгол Улсын  
Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг





2020 оны эхний  
байдлаар

**502**

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН  
байгууллага  
тогтвортой үйл  
ажиллагаа явуулж  
байна.

Эх сурвалж: Хэвлэлийн хүрээлэн, 2021

- 5) шүүгч нарыг бүх насаар нь томилох;
- 6) шүүгч нарын цалин нь амьдралд хүрэлцээтэй байх;
- 7) шүүгч нар боловсрол, туршлагын хувьд наад захын өндөр шаардлага хангасан байх;
- 8) шүүгчийг дэвшүүлэх нь түүний мэргэжлийн мэдлэг, туршлага, ёс зүйн чанарыг бодитоор үнэлсний үндсэн дээр хийгдэх;
- 9) шүүгчид сахилгын арга хэмжээ ногдуулах буюу огцуулах ажиллагааг гагцхүү сахилгын зөрчил гаргасан, эсхүл ажил эрхлэх чадваргүй болсны үндсэн дээр ихэнх төлөв буюу бүхэлдээ шүүгч нараас бүрдсэн сахилгын хороогоор хэрэгжүүлэх учиртай.

Шүүхийн бие даасан байдал, шүүгч нарын хараат бус байдлыг бэхжүүлэх талаар Монголын төр дорвitoй алхам хийж, дэлхий нийтийн жишигт нийцсэн байдлаар хуульчлан тогтоосон боловч хуулийн хэрэгжилтийг илэрхийлэх шүүхийн хараат бус байдлын үнэлгээгээр Монгол Улс 140 гаруй улсаас 120-д жагсаж байна. Сүүлийн 8 жилд иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс гаргасан 191 гомдолд сахилгын хэрэг үүсгэснээс 80-д нь сахилгын шийтгэл ногдуулахаар шийдвэрлэжээ.

Сонгодог утгаар нь “орон нутгийн засаг” буюу орон нутгийн бие даасан засаг захиргааны шинжийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

- 1) Үндсэн хуулийн дагуу тухайн нутаг дэвсгэртээ эрх барих чиг үүргийг хэрэгжүүлж, орон нутгийн үйлчилгээний талаар хариуцлага хүлээдэг;
- 2) санхүү, төсвийн хувьд бие даасан, орлогоо өөрөө бүрдүүлэх эрх мэдэлтэй;
- 3) хүний нөөцийг томилох, ажлаас халах, дэвшүүлэх эрх мэдэлтэй;
- 4) олонхиын намаас сонгогдсон хурлын байгууллага орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлж, дотооддоо мөрдөх дүрэм гаргаж хэрэгжүүлдэг;
- 5) төрийн захиргааны төв байгууллагуудын албан тушаалтнууд зөвхөн зөвлөгөө өгөх, мэргэжлийн хяналт хийх үүрэгтэй болохоос биш орон нутгийн бүрэн эрхэд хамаарах асуудалд оролцогтгүй байх” гэж тодорхойлдог.

Монгол Улс Авлигын үзүүлэлтээр 35 оноо авч, 180 орноос 111 дүгээрт бичигдэж байна. Авлигаас ангид засаглалыг бэхжүүлэхэд авлигатай тэмцэх, олон нийтийн дунд авлигыг үл тэвчих хандлага бий болгох, шударга ёсны тогтолцоог илүү бэхжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хүний эрхийг дээдэлсэн нийгмийн гол үзүүлэлт бол хэвлэлийн эрх чөлөө билээ. Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар 2020



Зураг 2. Дэлхийн улс орнуудын эрх чөлөөний байдлын үзүүлэлт (Тэргүүлэгч орнууд ба Монгол)

УЛС	НИЙТ ОНОО	СТАТУС	УЛС ТӨРИЙН ЭРХ
Норвеги	100	40	60
Финланд	100	40	60
Швед	99	40	60
Шинэ Зеланд	99	40	59
Канад	98	40	58
Дани	97	40	57
Нидерланд	97	39	58
Люксембург	97	38	59



**МОНГОЛ**

**84** НИЙТ ОНОО

**36** СТАТУС

**48** УЛС ТӨРИЙН  
ЭРХ

Эх сурвалж: Freedomhouse, 2022

оны эхний байдлаар Монгол Улс 502 хэвлэл мэдээллийн байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн 140 нь телевиз, 51 нь радио, 84 нь сонин, 73 нь сэтгүүл, 154 нь цахим мэдээллийн сайтууд байна. Жил бүр “Хил хязгааргүй сэтгүүлчид” олон улсын байгууллагаас эрэмбэлдэг хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтээр 2019 онд 180 орноос 70 дугаарт, 2020 онд 73 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Тус байгууллагын үнэлгээгээр Монголын хэвлэл мэдээллийн 10 байгууллага тутмын нэг нь л өмчлөлийн талаар ил тод зарладаг харин дийлэнх хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч эсвэл өмчлөгч нь улс төртэй холбоотой байдаг учраас хэвлэл мэдээллийн хэрэгслийн ардчиллын төлөө хараат бусаар ажиллах байдал хязгаарлагдмал гэсэн дүгнэлт гарчээ. Харин ардчилсан нийгмийн үндсэн үзүүлэлт болох эрх, эрх чөлөөний үнэмлэхүй үзүүлэлтийн тухайд АНУ-ын “Freedom house” төрийн бус байгууллагаас жил бүр эрэмбэлдэг “Freedom in the World 2022” үзүүлэлт (индекс)-д Монгол Улс улс төрийн эрхийн үзүүлэлтээрээ 40-өөс 36 оноо авсан бол иргэний эрхийн үзүүлэлтээр 60-аас 48 оноо авч, нийлбэр 84 оноогоор “ЭРХ ЧӨЛӨӨТ ОРОН” ангилалд багтсан. Уг ангилалд Ази тивээс Япон, Өмнөд Солонгос, Тайвань, Израйл, Зүүн Тимор зэрэг улс мөн багтжээ.

Засаглалын тогтолцоонд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж, хяналттай, хариуцлагатай төрийн үйл ажиллагааг төлөвшүүлэхийн тулд эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг зохицой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал.

#### Эрх чөлөөт орон

Ази тивийн 49 улсаас (НҮБ-ын гишүүнчлэлтэй) цөөхөн улс эрх чөлөөт орон гэсэн үнэлгээ авдаг ба тэдгээрийн нэг нь манай улс юм.

## ЗАСАГЛАЛ

## УХААЛАГ ЗАСАГЛАЛ

**ЗОРИЛГО 5.1** Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана.

## ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Хариуцлагатай, үр нөлөөтэй засаглалыг бэхжүүлэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**


Хариуцлагатай, үр нөлөөтэй засаглалыг бэхжүүлэх үе

Ухаалаг засаглалын шинж байдлыг иргэдийн өргөн оролцоог хангах, хууль дээдлэх ёсонд үндэслэн шийдвэр гаргах, засгийн газрын үйл ажиллагаа ил тод явагдах, иргэдийн хэрэгцээ, сонирхлыг мэдрэх, бүх иргэдэд тэгш хандах, төсвийг үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулах, улстөрийн хариуцлагатай байх, хөгжлийн төлөвлөлтөд алсын хараатай хандах явдал хэмээн тодорхойлсон байdag.

### ЭРХ МЭДЛИЙН ЗОХИСТОЙ ХУВААРИЛАЛТ БУХИЙ ИРГЭН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛ


Ардчилсан улсад төрийн эрх мэдлийг харилцан хяналттай, тэнцвэртэй хуваарилдаг. Энэ нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал нь бие даасан, хараат бус байж, харилцан хяналттай байх ёстой гэсэн үзэл санаа билээ. Өөрөөр хэлбэл, эрх мэдэл хоорондын хяналт-тэнцэл хангагдах тусам хуваарилалт зөв байна гэсэн үг.

Үндсэн хуулиар тогтоосон төрийн байгуулал нь эрх мэдэл хуваарилах, хяналт-тэнцлийн тогтолцоог агуулдаг. 1992 оны Үндсэн хуульд эрх мэдлийн гурван салаа мөчрийг анх удаа сонгодог утгаар нь хуваарилж, харилцан хяналт тэнцвэртэй байлгах зарчмыг тусгасан. Тэр дундаа хууль тогтоох (УИХ), гүйцэтгэх (Засгийн газар) эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангах шаардлагатай юм. Дэлхийн улсуудын парламентын эрх мэдлийн түвшнийг харьцуулсан үзүүлэлт (индекс)-ээр манай улс Итали, Германтай зэрэгцэн дээгүүр байранд ордог.





Зураг 3. Дэлхийн улс орнуудын засаглалын хэлбэр



Тиймээс Ундсэн хуулийн 2019 онд баталсан нэмэлт, өөрчлөлтөд гүйцэтгэх засаглалыг илүү тогтвортой байхад чиглэсэн зохицуулалт хийгдэж, Ерөнхий сайд танхимаа бие даан бүрдүүлэх боломжийг бий болгосон. Тухайлбал, УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээр ажиллах тоог хязгаарлаж, танхимын бүрэлдэхүүнээ тогтоон, сайд нараа томилох, чөлөөлөх эрхийг Ерөнхий сайдад олгосон билээ. Эл нэмэлт, өөрчлөлтийг мөрдөх хүртэл сайдыг огцруулах саналыг УИХ хүссэн үедээ гаргах боломжтой байв. Өнгөрсөн хугацаанд парламент Ерөнхий сайдыг огцруулах саналыг 10 удаа гаргаж, зургаа нь дэмжигдэн Засгийн газар огцорч байжээ. Харин сайдыг огцруулах саналыг 12 удаа гаргаж, хоёрт нь дэмжигдсэн байх жишигтэй. Аль нэг сайдыг огцруулах саналыг УИХ хагас жил тутамд хэлэлцэж байсан гэсэн үг. Үр дүнд нь 1992-2016 он хүртэл 11 удаа Засгийн газар солигджээ. Ийнхүү Засгийн газар огцрох бүрд яам, агентлагийн тоо, чиг үүрэг, нэрийг нь хүртэл өөрчилсөөр ирсэн. Түүнчлэн Засгийн газрын өргөн барьсан төсвийн төслийг нь хууль тогтоогчид танигдахгүй болтол өөрчилж, зардлыг тооцоо

#### Засаглалын хэлбэр

Дэлхий дахинд ерөнхийлөгчийн, холимог, парламентын засаглал зонхицж байна.

Тогтвортой байдал  
Ерөнхий сайд танхимаа  
бүрдүүлснээр бодлогын  
залгамж чанар, тогтвортой  
байдал хангагдаж, Засгийн  
газар кабинетын зарчимд  
шилжиж, үйл ажиллагааны үр  
ашиг, үр бүтээмж дээшилнэ.

судалгаагүй өсгөсөн байхад ч гүйцэтгэх засаглалынхан хүлцэхээс өөр сонголтгүй явж ирсэн. Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаанд хэт хутгалдахгүйтгээр хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих үйл ажиллагааг эрчимжүүлж, ардчилсан парламентын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн зорилт дэвшүүлсэн. Засгийн газрын тогтвортой байдал, бодлогын залгамж чанар хангалтгүй байгаа нь иргэдийн ахуй амьдралд шууд нөлөөлж, олон нийтийг эмзэглүүлдэг асуудал билээ.

Засгийн газрын эрхмэдлийг нэмэгдүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бодитоор хэрэгжүүлэх, Засгийн газрын тогтвортой байдал, бодлогын залгамж чанарыг хангах нь чухал. Иймд Засгийн газар урт хугацааны хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны төлөвлөгөөг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхээр хуульчилсан. Тухайлбал "Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийг үе үеийн Засгийн газар хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсвийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулах тогтолцоонд шилжиж байна. Ингэснээр Засгийн газар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг чигээ болгон, танхимины зарчмаар хариуцлагатай, тогтвортой үр дүнтэй ажиллаж, бодлого хөтөлбөрөө тuuштай хэрэгжүүлэх

Зураг 4. Гүйцэтгэх засаглалын тогтвортой байдлын үзүүлэлт

**1.7**  


жил

1992-2019 оны  
хооронд ажилласан  
Засгийн газруудын  
бүрэн эрхийн  
дундаж хугацаа

**3**  


сар

Хамгийн богино настай  
Засгийн газар  
1998.04.23-нд байгуулагдаж  
3 сар ажиллаад  
1998.07.24-нд огцорчээ.

**2**  


**Засгийн  
газар**

Бүрэн эрхийн  
хугацаагаа дуустал  
бүтэн ажилласан  
Засгийн газрын  
тоо (1992-1996  
оны П.Жасрайн,  
2000-2004 оны  
Н.Энхбаярын)

1992-2019 оны байдлаар

**15**  


**Ерөнхий сайд**

1992-2019 оны хооронд  
ажилласан ерөнхий сайд  
нар, давхардсан тоогоор  
(Ц.Элбэгдорж, С.Баяр нар  
тус бүр 2 удаа)

**4**  


**сайд**

2016-2019 оны хооронд  
буюу 3 жилийн хугацаанд  
ажилласан Боловсрол,  
соёл, шинжлэх ухаан,  
спортын сайдын тоо



нөхцөл боломж бий болно. Тухайлбал, Монгол Улсын үе үеийн Ерөнхий сайд нар бол Монгол төрийн ой санамж бөгөөд бодлогын залгамжийг бий болгодог.

Улсын Их Хурлын гишүүнд тавих ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахад хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхээс гадна намууд сонгуульд нэр дэвшигчдээ тодруулахдаа ёс зүй, сахилга хариуцлагын үндсэн шалгуурыг баримтлан гишүүд, дэмжигчдээр нээлттэй хэлэлцүүлдэг улс төрийн зөв соёлыг төлөвшүүлэх явдал юм. Улсын Их Хурлын гишүүдийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хуульд заасны дагуу эгүүлэн татах улс төрийн зэрэг соёл, хандлагыг бүрэн төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх юм. Үүний үр дүнд эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэр хангагдаж, засаглал илүү тогтвортой бөгөөд хяналттай болох юм.

Шүүх бол эрх мэдлийн тулгын гурван чулууны нэг бөгөөд хүний эрх, эрх чөлөөний баталгаа болсон институт билээ. Гэвч шүүх эрх мэдлийн байгууллагын зарим үйл ажиллагаа, шүүгчдийн ёс зүйн талаар олон нийт сөрөг үнэлгээ, хандлагатай байгааг судалгаа харуулдаг. Шүүхийн статистик мэдээллээс харахад хамгийн

#### Бодлогын залгамж

Монгол Улс ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш Ерөнхий сайдаар ажиллаж байсан эрхмүүдийн уулзалт бодлогын залгамжийн нэгэн хэлбэр юм.

бага ачаалалтай газрын шүүхийн нэг шүүгчид жилд дунджаар 84 хэрэг ногдож байна. Нэг жил бүх нийтээр амрах баяр болон амралтын өдрийг хасаад тооцвол нэг шүүгч ажлын гурван өдөр нэг хэргийг шийдэж дуусгах шаардлагатай нь харагдаж байна. Шүүгч хэргийн материалтай танилцаж, шүүх хуралдаанаар хэрэг маргааныг шийдэж, шийдвэрээ бичих ажиллагааг гурван өдөрт багтаах ёстой болж байна гэсэн үг.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд:

- Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгон үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
- Шүүх үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгох
- Ёс зүй, цогц чадамжтай шүүхийн хүний нөөц бэлтгэх суурь тогтолцоог бий болгож, төгөлдөржүүлэх зорилт, төлөвлөгөөг тодорхойлсон.

Үүний эхний алхам нь 2021 оны нэгдүгээр сарын 15-нд баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг





### Зураг 5. Сайн засаглалын үндэс



хэрэгжүүлэх ажил юм. Тус хууль нь Шүүхийн ерөнхий зөвлөл, бие даасан Сахилгын хороог байгуулахдаа оролцоог хангасан, нээлттэй байдлаар сонгон шалгаруулж ажиллуулах журмыг тогтоож, үүний үр дүнд мэргэшсэн, ёс зүйтэй, хариуцлагатай шүүх эрх мэдлийн тогтолцоог төгөлдөршүүлж, иргэдийн шударга шүүхээр хамгаалуулах эрхийг улам бүр баталгаажуулахад чиглэж байна.

Улс төрийн намуудын хямрал нь төрийн, цаашлаад эдийн засгийн, улмаар нийгмийн хямралд хүргэх аюултай. Самуэл Хантингтоны тодорхойлсноор "улс төрийн нам системийн хувьд тогтвортой болж, байгууллагын хувьд үнэт зүйлсийн нэгдэл болсон тохиолдолд институтчилагдсан гэж тооцож болно" гэжээ. Институтчилагдаагүй намууд хэт туйлширсан, тогтвортгүй, өрсөлдөх, итгэл хүлээх чадваргүй байдаг тул хүчтэй серег хүчин гарч ирж чаддаггүй байна. Монголд харьцангуй хоёр том нам нь ээлжлэн эсхүл эвсэн төрийн эрхийг барьж ирсэн боловч 1992 оноос хойших 16 удаагийн Засгийн газрын ихэнх нь бүрэн эрхийн хугацаагаа дуусгаж байгаагүй. Энэ нь улс төрийн намууд институтчилагдаагүйн илрэл гэж судлаачид дүгнэсэн байдал.

Өөр нэг асуудал бол Монголын улс төрийн намууд эрх мэдлийн төлөө өрсөлдөх бус бодлогын асуудалд анхаарах нь чухал байна. Намууд ялгаатай байр суурьтай асуудлаар жинхэнэ бодлогоо уралдуулах чиглэлээр хөгжих, энэ соёлд тасралтгүй суралцах ёстой. УИХ-ын гишүүд улс орны хөгжил, бодлогын асуудалд анхаарал хандуулах, үндэсний эрх ашгийг нэгдүгээрт тавих гэхээсээ илүү сонгогдсон тойротоо хамааралтай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, аж ахуйн шинжтэй асуудалд анхаарах үзэгдэл бий. Үүнийг улс төрийн популизм, сонгуулийн мажоритар тогтолцоотой холбож үздэг. Сонгуулийн тогтолцоог үндэсний нийтлэг сонирхлыг хангаж чадахуйц хэлбэрээр шинэчилж чадвал энэ дүр зураг өөрчлөгдөх боломжтой. Эдийн засгийн бүтэц өөрчлөгджэх байгаа өнөөгийн нөхцөлд энэ нь санаа зовоох асуудал мөн гэдгийг судлаачид онцолж байна.

Монгол Улсад Дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн 35 нам үйл ажиллагаа явуулж байна.

Иймд:

- Улс төрийн намуудын дотоод ардчиллыг бүх түвшинд сайжруулах;
- Ардчиллын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлж, төрийн бодлогод иргэдийн оролцоог дэмжих;
- Намуудыг бодлогын нам болгон төлөвшүүлж, улс орны эдийн засаг, нийгмийн өмнө тулгарч байгаа голлох асуудал, түүнийг шийдвэрлэх урт хугацааны бодлого боловсруулж батлахад зөвшилцэлд хүрэх тогтолцоог бүрдүүлэх;
- Улс төрийн намуудыг улсын төсвөөс тодорхой шалгуурын дагуу санхүүжүүлж, зарцуулалтыг олон нийтэд нээлттэй, ил тод, хяналттай болгох;
- Улс төрийн намыг хатуу гишүүнчлэлгүй болгох зорилтуудыг тодорхойлсон юм.

*Ардчилсан сонгуулийн түүх*

1992 оноос олон намын өрсөлдөөн бүхий чөлөөт сонгуулиар хууль тогтоох дээд байгууллагыг сонгох найман удаагийн сонгууль болжээ.

Монгол улсад сонгуулийн тогтолцоо 1992 оноос хойш харьцангуй олон санал авсан нэр дэвшигч сонгогддог мажоритар тогтолцоог ашиглаж ирэв. 2012 онд мажоритар ба хувь тэнцүүлсэн системийн 48:28 гэсэн харьцаа бүхий холимог тогтолцоог нэвтрүүлэх хууль батлагдаж хэрэгжүүлсэн.

Холимог тогтолцоо нь нийгмийн цөөнхөд өөрийн төлөөллийг парламентад суудалтай болгох боломж олгодог, олон намын тогтолцоог бий болгож энэ нь зөвшилцэл, харилцан ойлголцол дээр суурилсан улс төрийн соёлыг бүрдүүлдэг давуу талтай гэж үздэг. "Үндсэн хууль зөрчиж байна" гэсэн Үндсэн хуулийн цэцийн

Хүснэгт 1. УИХ-ын Сонгуулийн үр дүн (1992-2020)

	1992	1996	2000	2004	2008	2012	2016	2020
Сонгуульд оролцсон нам, эвсэл	8 нам, 2 эвсэл	5 нам, 2 эвсэл	13 нам, 2 эвсэл	7 нам, 1 эвсэл	12 нам, 1 эвсэл	11 нам, 2 эвсэл	12 нам, 3 эвсэл	13 нам, 4 эвсэл
Нийт нэр дэвшигч	293	302	602	244	356	544	498	606
Бие даан нэр дэвшигч	18	35	27	15	45	26	69	121
Нам, эвслээс нэр дэвшигч	275	267	575	229	311	518	429	485
Сонгогчдын ирц	95.6	92.1	82.4	82.2	76.4	67.2	73.5	73.6
Сонгуулийн тогтолцоо, систем	Мажоритар	Мажоритар	Мажоритар	Мажоритар	Мажоритар	Холимог	Мажоритар	Мажоритар
Олонх болсон нам ба үр дүн	МАХН-70 МоАН эвсэл-4 МСДН-1 Бие даагч-1	Ардчилсан холбоо эвсэл-50 МАХН-25 МУНН-1	МАХН-72 ИЗНН-1 Ардчилсан холбоо эвсэл-1 Бусад-2	МАХН-36 Эх-орон-АН-36(2) АН-36(2) БНН-1 Бие даагч-3	МАХН-45 АН-28 ИЗН-1 МНН-1 Бие даагч-1	АН-35 МАН-26 Шударга ёс-10 ИЗНН-2	МАН-65 АН-9 МАХН-1 Бие даагч-1 Бие даагч-3	МАН-62 АН-11 ХҮН-1 Бие даагч-2

Эх сурвалж: Удирдлагын академи, 2019



Зураг 6. Дэлхийн улс орнуудын сонгуулийн оролцооны үзүүлэлт



Эх сурвалж: Statista, 2020

дүгнэлт гарсан тул Сонгуулийн тухай хуулийг дахин өөрчилж, УИХ-ын 2016 оны сонгуулийг нэг мандаттай тойрог бүхий мажоритар тогтолцоогоор явуулсан. Үүнийг гаднын ажиглагчид нэгэнт хүрсэн түвшнээсээ ухарсан алхам болсон гэж дүгнэж байв. Энэ бүхэн манайд сонгуулийн хууль ихээхэн тогтвортгуй, сонгууль болгоны өмнөхөн өөрчлөгджэй байсныг харуулж байна. Иймд сонгуулийн тогтолцооны асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зорилтын хүрээнд Улсын Их Хурлын сонгуулийг холимог системээр явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхээр тусгасан юм.

Өнгөрсөн хугацаанд бүртгэлтэй сонгогчдын ирц 1990 онд 98% байсан бол 2000 онд 82.42%, 2016 онд 72.1%, 2020 онд 73% болж буурч иржээ. Иймд Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийг зэрэг явуулах, сонгуулийн байгууллагын бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлж, сонгуулийн үед санал хураах үйл явцын аюулгүй байдлыг хангаж, зөрчил, маргаангүй сонгууль явуулах нөхцөлийг бүрдүүлэх, иргэд, сонгогчдын улс төрийн мэдлэгийг дээшлүүлэх шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тухайлбал, сурагчдад сонгуулийн оролцооны тухай ойлголтыг гүнзгий өгөх болон залуучуудын оролцоог хангах чиглэлээр мэдээллийн технологийн давуу талыг ашиглах зэрэг олон талт үйл ажиллагаа явуулах шаардлагатай нь олон улсын жишигээс харагдаж байна.

#### Иргэдийн оролцоо

Сонгуульд иргэд идэвхтэй оролцох нь ардчилал, эрх чөлөөний нэг үндсэн үзүүлэлт. Нөгөө талаас засаглалд тавих хяналтын арга механизмыг болдог.

## ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Улсын Их Хурлын хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөвлөх хяналт тавих чадавх сайжирч, парламентын засаглалыг бэхжүүлнэ. Ард түмний засаглах эрхийг хангасан, итгэл хүлээсэн хууль тогтоох байгууллага төлөвшихдээ УИХ-ын гишүүнд тавих ёс зүйн асуудлыг өндөрт тавьж, намууд сонгуульд нэр дэвшигчдээ тодруулахдаа ёс зүй, сахилга хариуцлагын үндсэн шалгуураар гишүүд, дэмжигчдээ нээлттэй хэлэлцүүлдэг улс төрийн зөв соёлыг төлөвшүүлнэ. Хууль тогтоох үйл явц нотологоо, судалгаанд тулгуурласан байх тогтолцоог бэхжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй хэлэлцүүлэг өрнөсөн цахим парламентын горимыг хэвшүүлнэ.

Зураг 7. Монгол Улсын Их хурлын Алсын хараа



Эх сурвалж: Монгол Улсын Их Хурал, 2019

### Өргөн хэлэлцүүлэг


Хуулийн төслийг хэлэлцэх, олон нийтэд мэдээлэл, үйл явцыг илүү нээлттэй болгон, хэлэлцүүлэгт орон зайнаас үл хамааран иргэд оролцох боломжийг бүрдүүлж, цахим орчинд санал авах, мэдээлэл өгөх бололцоог нэмэгдүүлнэ.



# ИРГЭДЭЭ ДЭЭДЭЛСЭН ШҮҮХ

Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, үйл ажиллагааг боловсронгуй болгон үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, иргэдийн шүүхэд итгэлийг дээшлүүлнэ. Шүүхийн хараат бус байдал бүрэн хангагдаж, хариуцлагатай иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинэ. Шүүх үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгоно.

Зураг 8. Монгол Улсын шүүхийн тогтолцоо



Эх сурвалж: Монгол Улсын Их Хурал, 2015

## ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ:

Хуульчдаас шүүгчийг шилж олох,  
эрх ашгийг нь хамгаалах чиг  
үүргийг бие даан хэрэгжүүлдэг.  
Орон тооны 10 гишүүнтэй.

## ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО:

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан  
тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын  
бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий 9 гишүүнтэй  
бөгөөд бие даан ажиллах эрх зүйн орчинтой.

## НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ

Шүүх засаглалд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлж, олон нийтийн оролцоог ханган шүүхийн ерөнхий зөвлөл, сахилгын хороо зэрэг институцийн бүрэлдэхүүний томилгоонд нээлттэй сонсгал, сонгон шалгаруулалт явуулж хэвшигүүлнэ.

## ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗАЛГАМЖ



Олон намын тогтолцоог бэхжүүлэх замаар улс төрийн намуудыг бодлогын нам болгох улс төрийн соёлыг төлөвшүүлнэ. Улс төрийн намын дотоод ардчиллыг бүх түвшинд сайжруулж, ардчиллын үнэт зүйлсийг түгээнэ. Намыг тодорхой шалгуурын дагуу улсын төсвөөс санхүүжүүлж, зарцуулалтыг олон нийтэд ил тод, хяналттай болгоно. Улс төрийн намууд улс орны эдийн засаг, нийгмийн өмнө тулгарч байгаа голлох асуудал, түүнийг шийдвэрлэх урт хугацааны бодлого боловсруулж батлахад зөвшилцэлд хүрэх тогтолцоог бүрдүүлж, хөгжлийн бодлогын тогтвортой байдлыг хангана.



### Хөгжлийн бодлогын залгамж


Улс төрийн намууд Үндсэн хуулиа баримтлан улс орны хөгжил дэвшилийн талаар тогтвортой, залгамж чанартай бодлого хэрэгжүүлж байх үндэс нь хөгжлийн бодлогын залгамж чанар билээ.



# СОНГУУЛИЙН ХАРААТ БУС ТОГТОЛЦОО

Сонгуулийн байгууллагын бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлж, сонгуулийн үед санал хураах, харуулах үйл явцын аюулгүй байдлыг хангаж, зөрчил маргаангүй сонгууль явуулах нөхцөлийг бүрдүүлнэ. Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдүүлж, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлж, иргэд сонгогчдын хариуцлагыг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Зураг 9. Улс орнуудын сонгуулийн тогтолцоо



## Сонгуулийн зохион байгуулалт

Сонгуулийн байгууллагын бие даасан байдлыг нэмэгдүүлж, сонгуулийн үйл явцыг нээлттэй ил тод зохион байгуулах, сонгуулийн санал хураалтын үйл явцыг ойлгомжтой, шударга явуулж, чөлөөт, ардчилсан сонгуулийн тогтолцоог бэхжүүлнэ.

ЗАСАГЛАЛ

# УХААЛАГ БҮТЭЦ

**ЗОРИЛГО 5.2** Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.

хөгжлийн үе шат • ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог төлөвшүүлэх үе.

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Иргэдийн эрх ашгийг дээдэлсэн, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжсэн цомхон бөгөөд үр ашигтай, үр нөлөөтэй бүтэц, зохион байгуулалтыг төрийн байгууллагуудын бүх түвшинд нэвтрүүлэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**


Төрийн бодлого, үйл ажиллагааг иргэн төвтэй болгож, ухаалаг засаглалыг дэмжсэн бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх үе

Монгол Улсын Үндсэнхууль, бусадхууль тогтоомжийнхүрээнд төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээний тэдхүргэхүйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтын институцийг төрийн алба гэж тодорхойлдог. Энэ институцийн бэхжил, төлөвшлөөр төрийн ухаалаг бүтэц тодорхойлогдоно.

**ТӨРИЙН БҮТЦИЙГ ТӨГӨЛДӨРШҮҮЛЭХҮЙ**

Монгол Улсын төрийн албыг цомхон, чадварлаг, орчин үеийн болгох тухай уриа зорилт өнгөрсөн 30 жилийн турш улстөрчид болон судлаачид, олон нийтийн хүлээлт, зорилго байж ирсэн ч бодит байдал дээр биеллээ олоход багагүй сорилт бэрхшээлтэй тулгарсаар ирсэн.


Төрийн албандаа чадахуйн зарчимд тулгуурласан тогтолцоо бүрэн бүрдээгүйгээс үүдэлтэйгээр Засгийн газар удаа дараа солигдох бүрд албан хаагчдыг халж сэлгэх нь ард иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, үр дүнтэй хүргэхэд сөргөөр нөлөөлдөг. Өнгөрсөн хугацаанд бүрэлдэн тогтсон албан тушаалын улстөржсөн томилгоо, халаа сэлгээг зогсоох нь томоохон сорилт хэвээр байна. Дэлхийн банкнаас 2020 онд гаргасан “Өндөр чадавхтай төрийн албыг бий болгох нь: Шинэтгэлийн явц, сургамж” тайланд улстөржилт еренхийдөө хоёр хэлбэрээр өрнөсөн талаар





## ТӨРИЙН УХААЛАГ БҮТЭЦ

Монгол төрийн бүтэц цомхон чадварлаг байх боломжтой. Үндсэн хуульд заасан төрийн эрх мэдлийн хуваарилалт хэрэгжих чадвартай байх нь нэн тэргүүний асуудал болно. УИХ нь хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэг, Засгийн газар нь гүйцэтгэх эрх мэдлээ бие даан шийдэх чадвартай, хариуцлагаа бүрэн хүлээдэг, Шүүх нь хараат бусаар ажиллах боломжтой байх нөхцөл хангагдах ёстой. Үүнийг хэрэгжүүлэхдээ хүний тоонд бус, хүнээс хамаарал багатай байдлаар шийдэх нь ухаалаг бүтцийг бий болгох үндсэн шаардлага юм. Тогтвортой, чадахуйн зарчмаар томилогдсон төрийн албан хаагчидтай, цахим засаглал иж бүрэн нэвтэрсэн, шуурхай, ил тод, нээлттэй, гаргаж байгаа шийдвэр нь ойлгомжтой, иргэн болон бизнесийн байгууллагадаа үйлчилдэг тогтолцоог буюу институц байгуулахыг зорьж байна. Иргэдийн итгэл хүлээсэн “данхар бус” ардчилсан төрийг бий болгоно.



дурдсан байна. Үүнд төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас халах, албан тушаалд сонгон шалгаруулалтгүйгээр мэргэжлийн бус хүнийг томилох асуудал багтаж байна. Ялангуяа сонгуулийн жилд идэвхэждэг энэхүү үзэгдлийн үр дүнд хүний нөөцийн халаа сэлгээ нэмэгддэг. Ингэснээр төрийн албаны чадавх суларч, хууль сахих байдал доройтож, төрийн албаны ёс суртахуун уналтад ордог байна. Түүнчлэн албан тушаалын тодорхойлолтыг томилогоороо яригдаж буй хүнд тааруулах, богино хугацааны гэрээ байгуулах, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг байнга хийж ажилтнуудад дарамт шахалт үзүүлэх үзэгдэл ч гарч байсан удаатай. Энэхүү нөхцөл байдлыг өөрчилж, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чадавх, механизмыг бэхжүүлэн улс төрчид, төрийн албан хаагчдын дунд тогтсон соёлыг өөрчилж, ёс зүйн хэм хэмжээг шинээр тогтоон улстөржилтийг багасгах шаардлагатай билээ. Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албанад ажиллах нөхцөл, баталгааг бүрэн хангасан улс төрийн, хууль эрх зүйн, эдийн засгийн тогтолцоог бэхжүүлэх, албан тушаалд томилоход мэргэжлийн мэдлэг, үр чадвар, ажлын үр дүн, улс болон салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг харгалздаг уян хатан тогтолцоог бэхжүүлнэ хэмээн зорилт дэвшүүлсэн.

Сүүлийн арван жилд (2009-2019) төрийн албан хаагчдын тоо 34%-иар нэмэгдсэн тухай Дэлхийн банкнаас дээрх тайланд дурдсан байна. Олон улсын жишигтэй харьцуулахад төрийн албан хаагчдын цалингийн зардал тийм өндөр биш боловч

2010 онтой харьцуулахад  
Төрийн албан  
хаагчдын тоо

**25%**  
өссөн байна.

2010 он - 155,679  
2021 он - 208,864

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл, 2022

төсвийн урсгал зардлын хувьд хамгийн өндөр өсөлттэй, хамгийн том бүрэлдэхүүн хэсэг хэвээр байна гэж тайланд дурджээ. Өргөн уудам газар нутагт төрийн үйлчилгээг хүргэхийн тулд орон тоог нэмэгдүүлэх нь шийдэл биш. Харин төлөвлөж буй шинэтгэлийн хүрээнд байгаа хүний нөөцөө үр дүнтэй удирддаг болох нь төрийн үйлчилгээ үзүүлэх бүтээмжийг дээшлүүлэхэд нэн чухал болохыг зөвлөсөн байна. Төрийн байгууллагын бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог бууруулахаар заасан юм.

Төрийн захиргааны шинэчлэлийн талаар дэлхий нийт 1980-аад оноос идэвхтэй ярьж эхэлсэн ба олон улсын туршлагаас харахад захиргааны байгууллагын үр дүнтэй үйл ажиллагаа, үр ашигийг нэмэгдүүлэхэд чиглэж байв. Үүний гол зорилго нь олон нийтийн амьдралыг сайжруулахын төлөө албан тушаалтны эрх мэдлийг бууруулах, авлигыг таслан зогсоох, төлөөллийг дэмжих, иргэд, олон нийтийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хариуцлага, ил тод байдлыг дээшлүүлэхэд анхаарч ирсэн байна. Төрийн захиргааны шинэчлэл нь улс төрийн хүрээтэй зайлшгүй холбогдож хэрэгждэг болохыг судлаачид хэлдэг. Жишээ нь төрийн өмчит аж ахуй нэгжүүдийг хувьчлах,

Зураг 10. Төрийн албаны ангилал





төрийн үйлчилгээг төлбөр хураамжтай болгох, ажилгүйдлийг бууруулах хөтөлбөрүүд боловсруулан батлах, мэдээллийн ил тод байдлыг дээшлүүлэх зэрэг өөрчлөлтийг хийхэд улс төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай болдог байна.

Монгол Улс төрийн захиргааны шинэчлэл явуулах оролдлогуудыг хийж ирсэн бөгөөд ололт амжилт, сорилт бэрхшээлийн аль алийг туулж байна. 1990 оны эхэнд хуучин дэглэмийг халж, ардчилсан шинэ тогтолцоог бурдүүлэх нөхцелийг бий болгох зорилгоор олон намын оролцоотой ардчилсан сонгууль явуулах, нам төрийн ажлыг тусгаарлах үндэс суурийг бүрдүүлж, шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлсэн байdag. Шинэ Үндсэн хууль батлагдсаны дараа үед буюу 2002 он хүrtэл Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн төрийн захиргааны институциональ бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэхэд чиглэсэн гол хуулиудыг баталжээ.

2002–2007 онд улсын салбарын шинэ менежментийн загварыг хэрэгжүүлэхийг зорьж байв. Энэ үед “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль”-ийг батлан мөрдөж, төрийн салбарт стратегийн болон гэрээний удирдлагын үзэл санаа нэвтэрсэн байна. 2008–2019 онд улс төрийн нөлөөллөөс ангид төрийн мэргэшсэн, тогтвортой албыг төлөвшүүлэхэд анхаарч, төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчдын улс төрийн намын гишүүнчлэлийг хязгаарлах замаар төрийн албаны залгамж чанарыг хадгалах, гүйцэтгэлийг сайжруулах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхийг зорьсон байdag. Мөн УИХ-ын 2008 онд баталсан “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийн бодлогыг тусгасан. Үүнтэй уялдуулан Засгийн газар 2016 онд “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”, “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал” зэрэг бодлогын баримт бичгүүдийг баталжээ. “Төрийн албаны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг 2019 оноос дагаж мөрдсөнөөр улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албаны эрх зүйн үндэс бүрдэж, төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн алба хаших шалгуур нь зөвхөн мэргэшлийн болон уг албыг гүйцэтгэх мэдлэг чадвар, мэргэжлийн ёс зүйгээр тодорхойлогддог болох нөхцөлийг баталгаажуулахаар ажиллаж байна.

---

Албаны ангилал, онцлог  
Төрийн албаны ангиллаас төрийн үйлчилгээний алба хамгийн олон хүнтэй бол төрийн захиргааны алба хамгийн цөөн боловч цомхогтголд хамгийн их өртөмтгийг аж.

Ухаалаг бүтцийг бий болгохын тулд төрийн чиг үүргийн шинжилгээнд үндэслэн давхардал, хийдэлгүй бүтэцтэй байхыг зорьж байна.

Судлаачдын үзэж байгаагаар Монгол Улс ардчилсан, өндөр хөгжилттэй орнуудад хэрэгжиж буй захиргааны шинэчлэлийг богино хугацаанд хэрэгжүүлж байгаа ч нийгмийн сэтгэлгээний хүрээнд ардчилал, засаглал хуваарилах зарчмын болоод захиргааны тогтолцоог иргэнд үйлчлэх, иргэн төвт байр сууриас хандах үнэт зүйлийг бүрдүүлж өгчээ. Гэвч төрийн албыг цомхон, бүтээмжтэй, эдийн застийн үр ашиг, өгөөжтэй байлгах, улсын төсөв, санхүүг дэмжих зорилгоор шинэчлэлийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Үүний тулд юун түрүүнд хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурласан төрийн захиргааны оновчтой, уян хатан, үр дүнтэй, үр ашигтай бүтцийг тодорхойлон бий болгоно. Үүнтэй уялдуулан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарилалтыг ч гэсэн хөгжлийн бодлогод тулгуурлан оновчтойгоор дахин тогтоо замаар орон нутаг өөрөө бие даан хөгжих бололцоог бүрдүүлэхээр зорьж байна.

Застийн газрын бүтцийг Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого болон түүнийг эш болгосон Застийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн тогтоохоор заасан билээ. Энэ зорилтыг хангах чиглэлээр 2022 оноос Эдийн засаг, хөгжлийн

#### Замнал

Ардчилсан Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан гүйцэтгэх засаглал бүтцийн хувьд өнгөрсөн гучин жил ийм замналтай ирэв.


Зураг 11. Яам, агентлагийн тоо (1992-2022 он)



Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл, 2022



Зураг 12. Монгол Улсын Засгийн газрын яамд, агентлаг (2022)



яам, Цахим хөгжлийн яам гэсэн хоёр яамыг шинээр байгуулсан. Эдийн засаг, хөгжлийн яам нь Монгол Улсын хөгжлийн бодлогыг зангидаан төлөвлөж, төсвийн төлөвлөлтийг урьдчилан зурах цаашлаад бүс нутаг, тив дэлхийн хөгжлийн бодлоготой нэгтгэн уях замаар зөв бодлого тодорхойлж, зөв төлөвлөлт хийх ажлыг нэгтгэн зангидаах учиртай. Харин Цахим хөгжлийн яам нь Монгол Улсад цахим шинэчлэлийг эрчимжүүлэх, дэлхийн мэдээлэл технологийн салбарт экспортлогч орон болох зорилтыг хэрэгжүүлэхэд салбарын бодлогыг чиглүүлнэ. Энэ нь урт хугацааны хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх, бодлогын залгамж чанарыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэхэд чухал ач холбогдолтой.

Оновчтой, үр ашигтай тогтолцоонос гадна бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явц, журам нь тодорхой, ойлгомжтой, холбогдох талуудын оролцоог хангасан байх нь чухал билээ.

Эх сурвалж: Монгол Улсын Их Хурал, 2022;  
Монгол Улсын Засгийн газар, 2022

#### Төрийн бүтээмж

Төрийн бүтээмжийн сэргэлтэд төрийн үйлчилгээг цахимжуулах, үргүй зардлыг бууруулах, төр-хувийн хэвшлийн туншлэлийг бэхжүүлэх үйл явц голлох нөлөө үзүүлнэ.

## ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

 Хөгжлийн бодлогод нийцсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн оновчтой хуваарилалт бий болж, аймаг, нийслэл, сум, дүүрэг хуулиар олгосон нутгийн өөрөө удирдах ёс, засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор болж хөгжин, орон нутгийн бие даасан байдал хангагдана. Орон нутгийн хөгжлийн сангийн тогтолцоог боловсронгуй, хүртээмжтэй, зарцуулалтыг үр ашигтай болгосноор орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтворт суурьшилтай амьдрах орчин, нөхцөл бүрдэх нэг хүчин зүйл юм.

Зураг 13. Орон нутгийн хөгжлийн сан

### ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН (ОНХС)



Эх сурвалж: Монгол Улсын Их Хурал , 2011

#### Хот хөдөөгийн сэргэлт

Хоого хөгжүүлж, төвлөрлийг бууруулан түгжрэл багасгах шийдэл нь орон нутгийг хөгжүүлэх юм. Орон нутгийг бие даан хөгжих, санхүү эдийн засгийн боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.



# ТӨРИЙН БҮТЭЭМЖ



Төрийн бүтээмжийг дээшлүүлж, гэрээгээр гүйцэтгүүлж болох бүх төрийн чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагад шилжүүлэх тогтолцоог нэвтрүүлнэ. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо хангагдаж, хувийн өмчийг бүрэн хамгаалсан эрх зүйн орчин бүрдүүлнэ. Төр хувийн хэвшлийн түншлэл өргөжин, дэлхийд өрсөлдөх компаниудтай болно.

Зураг 14. Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ



## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛАХ

Төреөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна.



## ЗАСГИЙН ГАЗРЫН ОНОВЧТОЙ БҮТЦИЙГ ТОГТООХ

Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.



## ТӨРИЙН ДАВХАРДСАН ТОГТОЛЦООГ ЦЭГЦЭЛЖ, ЗӨВШӨӨРЛИЙН ТОOG БУУРУУЛАХ

Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг тур хугацаанд зогсоож, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцлийн тоог бууруулна.



## ТӨРИЙН АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮР АШИГ, ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ

Төрийн өмчтэй аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.



## АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ БУУРУУЛАХ

Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах яланы бодлогыг чангатгана.



## ҮР АШИГТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ

Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт (саарал, хар жагсаалт), Европын холбооны "Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бус нутгийн жагсаалт"-д орохгүй байх, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулаас сэргийлнэ.

### Төрийн албаны бүтээмж

Төрийн бүтээмж нь бодлого, институтаас хамааралтай бөгөөд хязгаарлагдмал нөөцийг иргэд, олон нийтийн хэрэгцээ, хүсэл сонирхолд тулгуурлан үр ашигтай бодлого, менежментээр хангах замаар хэрэгжине. Төрийн албан хаагчийн ур чадвар, сургалт, ажлын цаг ашиглалт, идэвхжүүлэлт, үнэт зүйлс чухал үүрэг гүйцэтгэдэг.

## ЗАСАГЛАЛ

## ЦАХИМ МОНГОЛ

**ЗОРИЛГО 5.3** Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.

## ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Эдийн засаг, нийгмийн бүх салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновацыг нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Хүний хөгжлийг дэмжсэн цахим засаглалыг хөгжүүлэх үе

Цахим засаглалыг “төрийн мэдээлэл болон үйлчилгээг иргэдэд хүргэх, шийдвэр гаргахад оролцуулах боломж бүрдүүлэх үүднээс төр засгийн зүгээс их өгөгдөл сууринсан үйл ажиллагаа явуулах” хэмээн тодорхойлсон байdag. Төрөөр хэлбэл цахим засаглал нь төрөөс иргэд, аж ахуйн нэгжүүдтэй өргөн хүрээнд харилцах, мөн төрийн мэдээллийн нээлттэй байдлыг хангах, засаглалд инновацыг бий болгох гэсэн утгаар ойлгогдон хэрэглэгдэж байна. Тодруулбал, цахим засаглалын үндсэн зарчим нь төрийн олон төрлийн байгууллагуудын үйл ажиллагааны урсгал, үйл явцыг нэгтгэн нийлүүлж, тэдгээрт зарцуулах хугацаа, санхүүгийн зардлыг бууруулах замаар нөөцийг үр дүнтэй ашиглах боломж олгож, үйлчилгээний тогтвортой шийдлүүдийг тодорхойлох явдал юм. Инновац, цахим засаглалын үр дүнд дэлхийн улс орнуудын төр засаг илүү үр ашигтай ажиллаж, илүү чанартай үйлчилгээ үзүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, иргэдийнхээ хүлээлтэд нийцэн ил тод, хариуцлагатай ажиллах боломж бүрдэж байна.

Төрийн захиргааны шинэчлэлийн хүрээнд Төрийн албаны шинэчлэл (New Public Service) идэвхтэй яригдаж байна. Энэ шинэчлэлийн онцлог нь ардчиллын онолд сууринсан, иргэдийн оролцоог идэвхтэй дэмжих хандлага юм. Тиймээс төрийн албан хаагчдад үнэт зүйл, ёс зүйн зарчмууд илүү хүчтэй тавигддаг. Учир нь нийгмийн суурь асуудлуудыг шийдэх гаргалгааг олоход иргэдийн оролцоо чухал бөгөөд төрийн албан хаагчдын хувьд тэр бололцоог хангаж, нээлттэй, ил тод, хариуцлагатай, эргэх





Зураг 15. Цахим шилжилтийн давуу тал



холбоотой ажиллах шаардлагатай болж байна. Энэ шинэчлэлд гол нөлөө үзүүлэх өөрчлөлт нь иргэний нийгэм, төрийн хоорондын харилцааг холбож буй цахим шилжилт юм. Цахим шилжилт нь төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог идэвхжүүлэхэд гол нөлөөтэй арга болоод байна. Мөн төрийн ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх, иргэд бодлого боловсруулагчдыг ойртуулах, цахим засаглалыг хөгжүүлэхэд ч шинэ технологи нь хувь нэмрээ оруулах гол хүчин зүйлийн нэг билээ. Төв, орон нутгийн захиргааны байгууллагууд мэдээллийн технологийн хөгжлийг түлхүү ашиглах болсон нь захиргааны үр ашгийг дээшлүүлээд зогсохгүй мэдлэг, мэдээллийн бааз суурийг хөгжүүлэх замаар захиргааны шинэчлэлийг хэрэгжүүлэх хүсэл зоригийг бий болгох ач холбогдолтой гэж үздэг. Төрийн албан хаагчдад шинээр бий болсон үйлчилгээ болон түүнийг дэмжсэн зохион байгуулалтын өөрчлөлтийг ойлгуулах, арга барилд сургах сургалт, үйл ажиллагааг эрчимтэй зохион байгуулах шаардлага бий болжээ. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд мэдээлэл, харилцаа холбооны дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоог дэмжих, төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, иргэд төрийн байгууллагын албан

Эх сурвалж: Цахим хөгжил, харилцаа, холбооны яам, 2021

#### Технологийн давуу тал

Төрийн үйлчилгээнд технологийн давуу талыг ашиглан үр ашгийг дээшлүүлж, зардал хэмнэн, хүнд суртлыг бууруулдаг. Мөн төрийн бодлого боловсруулалт, шийдвэр гаргалтын үйл явцад технологийн давуу талыг тулхүү нэвтрүүлэх хэрэгтэй.

Өгөгдөл мэдээллийн сүлжээ

Төрийн үйлчилгээг гар утаснаасаа авах боломжийг олгохын тулд бүх үйлчилгээний дэд системүүдийг холбосон, аюулгүй байдлыг нь шийдсэн, нэгдмэл мэдээллийн сантай цахим дэд бүтэц, программ хангамжийн отголцсон сүлжээ бий болгодог. Энэ нь өгөгдөл мэдээллийн сүлжээ (X-Road) юм.

тушаалтнуудтай цахим хэлбэрээр харилцах соёлыг хэвшүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн.

Мэдээлэл технологийн салбарын хөгжил дэвшил төр засагт өөрчлөгдөн шинэчлэгдэх зүй ёсны шаардлагыг бий болгож байна. Саяхан л жам ёсны мэт санагддаг байсан хүнд суртал, хүнээс хүн рүү цохож гүйлгэдэг төрийн үйлчилгээний бэрхшээл аажим аажмаар багасаж байна. Цахим засаглалын хөгжлийн үр дүнд бий болж буй эдгээр эзэрэг өөрчлөлт дэлхийн олон улс оронд ердийн л нэг үзэгдэл болсон бол бид ч дэлхийн хөгжилтэй зэрэгцэн оршиход чиглэсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүний тулд Монгол Улс сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд “Мэдээлэл холбооны технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал, “Монгол Улсын мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх дунд

Зураг 16. Цахим шилжилтийн давуу талын зураглал





хугацааны стратеги”, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр” зэрэг цөөнгүй бодлого төлөвлөлтийн баримт бичгийг батлан хэрэгжүүлсэн байдаг. Эдгээр нь тухайн цаг үедээ хэрэгжиж ирсний үр дүнд үндэслэн өдгөө Монгол Улсын Засгийн газар “Цахим Монгол” зорилтыг дэвшиүүлэн хэрэгжүүлж байна. Засгийн газар цахим орчин, мэдээллийн технологи, инновацыг ашиглан төрийн үйлчилгээг шуурхай болгох, ажлыг хөнгөвчлөх, хүнд суртлыг арилгах зорилго бүхий E-Mongolia нэгдсэн платформд төвлөрсөн үйлчилгээг нэвтрүүлсэн нь хамгийн богино хугацаанд үр дүнгээ өгсөн бодлогын хэрэгжилт болсон.

E-Mongolia нэгдсэн системийг ашиглан иргэд гар утас, компьютероо ашиглан төрийн үйлчилгээг шуурхай авах нөхцөл бүрдэж байна. E-mongolia системээс авах боломжтой төрийн үйлчилгээг авахын тулд иргэд өмнө нь хол ойр, унаа тэрэгний боломж, замын түгжрэл зэргээс үүдэн дунджаар 2 цаг 30 минутыг зарцуулдаг байсан бол цахим шинэчлэлийн үр дүнд иргэд цаг хугацаа болон санхүүгээ хэмнэх, цаашлаад төрийн үйлчилгээнээс үүдэлтэй стресс бухимдалд орохгүй байх, цаг заваа гэр бүлдээ, ажилдаа, өөрт хэрэгтэй үйл хэрэгт зарцуулах боломжийг олгож байгаагаараа онцлогтой.

Цахим шинэчлэл дэлхийн ихэнх оронд үр дүнтэй хэрэгжиж байгаагийн нэг жишээ Эстоны туршлага 20 гаруй жилийн түүхтэй. Тус улсын төрийн үйлчилгээний 99 хувь нь өдгөө цахим платформд шилжсэн бөгөөд иргэд нь жилдээ 100-120 нэр төрлийн төрийн үйлчилгээг цахимаар авдаг. Ингэснээр эстоничууд амьдралынхаа 10 өдөртэй тэнцэх цагийг хэмнэх боломжтой болсны дээр цахим аюулгүй байдлын системийг иргэдэд нээж өгснөөрөө давуу талтай. Энэ нь тухайн иргэн өөрийнх нь мэдээлэлтэй хэн, хэзээ, ямар зорилгоор танилцаж, шалгаж байгааг хянах, зөвшөөрөл өгөх эрхтэй бөгөөд энэ нь мэдээллийн аюулгүй байдлын баталгаа болдог.

АНУ ч 1990-ээд оны үед цахим шинэчлэлийг эхлүүлсэн бөгөөд дунд сургуулийг компьютероор хангаж, интернэттэй холбох ажлыг “Барын үсрэлт” нэртэйгээр үндэсний хэмжээнд эхлүүлсэн байдаг. Ингэснээр мэдээллийн технологийн хэрэглээг хүүхдүүдийн хүсэл сонирхолд тулгуурлан хөгжүүлсэн ба 2000 оноос төрийн үйлчилгээг цахимд шилжүүлэх ажлыг эхлүүлж, улмаар Засгийн газар нь цахимаар хуралддаг болсноос гадна татварын харилцааны 99 хувь нь цахим хэлбэрээр явагддаг болсон. 2002 онд цахим үнэмлэхийг нэвтрүүлж, иргэн бүр цахим шуудангийн хаягаараа дамжуулан төрийн үйлчилгээг авах болсон. Өөр нэг үсрэлтийн жишээ нь Австрали улс бөгөөд тус улс хоёр жилийн дотор цахим застийн хөгжлийн үзүүлэлт (индекс)-ээр үсрэнгүй хөгжиж, дэлхийд хоёрдугаарт эрэмбэлэгдэх болсон. Ингэхдээ



төрийн албандаа цахим манлайллыг үлгэрлэх, дэмжин ажиллах шинэ бүтцийг бий болгосон нь 2016 онд байгуулагдсан Цахим шилжилтийн агентлаг юм. Тус байгууллага төрийн үйлчилгээг цахим болгоход шаардлагатай хууль, эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулж, дүрэм стандартыг боловсруулж, иргэд олон нийтэд ойлгуулан таниулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Монгол Улс E-Mongolia нэгдсэн платформ хэрэглээнд нэвтэрсэн нэг жилийн хугацаанд 1.9 сая хэрэглэгч бүртгүүлж, 56 төрийн байгууллагын 540 нэр төрлийн үйлчилгээг цахимаар авч байна. Давхардсан тоогоор 6.2 сая гаруй үйлчилгээг цахимаар үзүүлсэн бөгөөд төрийн байгууллага руу ирж, буцах шаардагдах бичиг баримт бүрдүүлэх зардал, цаг хугацаа хэмнэх зэрэг нэг жилийн хугацаанд нийт 46 тэрбум төгрөг хэмнэсэн гэсэн тооцоо гарчээ. E-Mongolia хэрэглэхэд ч хялбар. Татвар, төлбөр тооцоо гэсэн товч дээр дарвал ААН-ийн орлогын албан татвар, ахуйн хэрэглээний ус ашигласны төлбөр зэрэг бүх хэрэгтэй жагсаалт тухайн багцад багтсан байна. Иргэн мэдээлэл, лавлагаа авахаас гадна иргэний үнэмлэх, гадаад паспорт, жолооны үнэмлэх захиалах бүрэн боломжтой. Хамгийн багадаа ажлын нэг өдрийт зарцуулж, дугаарлаж авах үйлчилгээг цахимаар Монгол Улсын 21 аймаг, 330 сумын хаанаас ч 2-5 минутын дотор авах боломж бүрдсэн. Олон нийтэд цахим соёл бий болгох, аппликашн хэрэглэх чадварыг дээшлүүлэх сургалт, мэдээллийг түгээх, үндэсний хэмжээнд зохион байгуулах шаардлагатай.

Зураг 17. Цахим шилжилтийн тулгуур бүтэц





Нийтээрээ цахим бичиг үсэгт суралцвал төрийн үйлчилгээ авах улам энгийн хялбар болно.

Эстони улс Европын холбооны мэдээлэл технологийн төв цэг болон хөгжиж буйн нэгэн адил манай улс бүс нутагтаа мэдээлэл технологийн салбарын хөгжлөөр тэргүүн эгнээнд багтах зорилт тавин ажиллаж байна.

Мөн бодлого төлөвлөлтийг судалгаа нотолгоонд тулгуурлаж тодорхойлоход улс орнуудын засгийн газар анхаарах болсон. Их өгөгдөл, блокчэйн технологи нь бодлого боловсруулагчдад уламжлалт эмпирик судалгаанаас илүү гүнзгий, өгөгдөл тулгуурласан мэдээлэлтэй болох боломжийг бүрдүүлж, тоон шинжилгээг бодлогын үйл явцад урьд өмнөхөөсөө илүү нарийн ашиглах боломжийг олгож байна. АНУ, Хятад, Их Британи, Энэтхэг зэрэг улсуудад залилангийн гэмт хэргийг илрүүлэх, санхүүгийн зах зээлийн шинжилгээ хийх, эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд, төрийн хяналт, боловсрол, гэмт хэрэгтэй тэмцэх, байгаль орчныг хамгаалах, эрчим хүчний хайгуул, хөдөө аж ахуй, цаг агаарын урьдчилсан мэдээ, экосистемийн менежмент зэрэг төрөл бүрийн үйл ажиллагаанд төрийн байгууллагууд их өгөгдлийг ашиглаж байна. Цахим засаглалын зорилтын хүрээнд тоон системд шилжих үйл явц хурдацтай өrnөж эхнээсээ төрийн байгууллагууд дата мэдээллийн сангаа илүү төрөлжүүлэн, урт хугацааны өгөгдөл, мэдээллээр баяжуулж байна.

#### МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний тогтолцоо
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтийн тулхүүрийн дэд бүтэц
- Үндэсний цахим халдлагаас хамгаалах хариу арга хэмжээ авах чадвар

#### ИННОВАЦ, ҮЙЛДВЭРЛЭЛ

- Үндэсний тоон контент
- Мэдээлэл, холбооны өндөр технологи инновацийн кластер
- Энтрепрёнер, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих
- Олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа

#### ЦАХИМ ЗАСАГЛАЛ

- Төрийн цахим үйлчилгээ
- Цахим эдийн засгийг дэмжих хууль эрхзүйн орчин
- Төрийн цахим шилжилт
- Нийтийн мэдээллийн дэд бүтэц

E-Mongolia хэрэглээнд  
нэвтэрснээс хойш нэг  
жилийн хугацаанд



# 1.9 сая

хэрэглэгч бүртгүүлж,

# 540+

цахим үйлчилгээ

# 6.2 сая

үйлчилгээг хэрэглэгчдээ  
хүргэжээ.

Эх сурвалж: ЦХХХЯ, 2022

Эх сурвалж: Монгол Улсын  
Засгийн газар, 2020

## ИРГЭН-ТӨР-БИЗНЕС БҮРТГЭЛ



Иргэн төр, бизнесийн байгуулагууд их өгөгдөл суурилсан мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, мэдээлэл солилцооны үүлэн технологид бүрэн шилжиж, ил тод төрийн албаны тогтолцоо бэхжэнэ. Иргэд өөрөө мэдээллээ хянах, хандалтыг зөвшөөрөх дүрмийн дагуу хэрэглээнд суралцана. Тоон гарын үсгийг хэрэглээнд хэвшүүлж, хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

Зураг 18. Цахим үйлчилгээ ба өгөгдөл, мэдээллийн солилцоо



### Бүх нийтийн мэдээллийн технологийн хэрэглээ

Өгөгдөл, мэдээлэл солилцооны нэгдсэн системд оролцогч талууд хамтын хучин чармайлтаар цахим үндэстний зорилтыг хэрэгжүүлнэ.



# НЭГДСЭН ПЛАТФОРМ НЭГ ИРГЭН-НЭГ БҮРТГЭЛ

 E-Mongolia төрийн нэгдсэн платформыг хөгжүүлэн, салбар бүрийн бие даасан системийг нэгтгэж, төрийн байгууллага хоорондын болон төр, иргэн, бизнесийн байгууллагуудын тусдаа байсан мэдээлэл, солилцоо сайжирч, захиргааны зардал буурч, үйлчилгээний үр дүн сайжирна. Цахим мэдээллийн нэгдсэн сан, өндөр хурдны интернэтийн сүлжээ, мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлж олон улсын жишигт нийцүүлнэ. Нэг иргэн-нэг бүртгэлээр төрийн үйлчилгээг авдаг байх тогтолцоог бүрдүүлнэ.



## E-Mongolia - нэгдсэн платформ

E-Mongolia нэгдсэн платформыг хөгжүүлснээр зөвхөн иргэдэд очих үйлчилгээ шуурхай болох төдийгүй иргэдийн хувьд цаг зав, хөрөнгө мөнгө хэмнэсэн, бизнесийн хувьд олон шинэ боломж нээсэн арга хэмжээ болно. Үүнийг хэрэгжүүлснээр дэлхийн хөгжилтэй эн зэрэгцээ оршино.

## ЗАСАГЛАЛ

# ЧАДВАРЛАГ, ЁС ЗҮЙТЭЙ, МЭРГЭШСЭН ТӨРИЙН АЛБА

**ЗОРИЛГО 5.4** Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.

## хөгжлийн үе шат • хүрэх үр дүн

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Нийгмийн хөгжлийг дэмжсэн, үр нөлөөтэй, цомхон төрийн албыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээний менежментийг олон улсын түвшинд хүргэж хөгжүүлэх үе


**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Нийгмийн хөгжлийг дэмжсэн, үр нөлөөтэй, цомхон төрийн албыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээний менежментийг олон улсын түвшинд хүргэж хөгжүүлэх үе

Төрийн алба гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг, төрийн албан хаагч гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ.


Аливаа орны төрийн алба хэдий чинээ мэргэшсэн, тогтвортой байх тусам тухайн улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн хүрээг хамарсан өөрчлөлт, шинэтгэлийн үр дүн төдий чинээ сайжирдаг. 1883 онд АНУ-ын сенатч Жорж Пендлтоны санаачлан батлуулсан Төрийн албаны шинэтгэлийн акт (“Пендлтоны хууль” гэж алдаршсан)-аар намууд сонгуулийн үр дүнгээр төрийн албан тушаалыг хуваарилдаг шударгы бус тогтолцоог өөрчилсөн. Энэ үеэс Америкт төрийн албаны чадахуйн тогтолцоо бүрдсэн гэж үздэг.

Төрийн албандаа тавигддаг олон улсын хүлээн зөвшөөрсөн зарчим бол “Мерит” буюу “Чадахуйн” зарчим билээ. Мерит гэдэг үгийг монгол хэлэнд хөрвүүлбэл “гавьяя зүтгэл, чанар чансаа, сайн тал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал” гэх мэт утгыг агуулдаг.





Зураг 19. Төрийн албан хаагчдын тоо (бүсээр), 2021 он.



“Чадахуйн зарчим” гэдэг нь төрийн мэргэшсэн албаны томилгоог улс төрийн нөлөөллөөс бүрэн ангид, шударга, ил тод, нээлттэй өрсөлдөөний зарчмаар шалгаруулах, зөвхөн хүлээн зөвшөөрөхүйц зүтгэл, үр дүн гаргасан албан хаагчийг тушаал дэвшүүлэх тухай тогтсон үзэл баримтлал юм. Хөгжингүй улс орнуудын туршлагаас харахад төрийн албаны улс төрөөс ангид, үйл ажиллагаагаа ил тод, ёс зүйтэй явуулдаг, цаг үргэлж суралцаж байх шаардлагыг төрийн албан хаагчдад тавих нь нийтлэг. Монгол Улсын төрийн албананд 2021 оны байдлаар 208.9 мяанган хүн ажиллаж байгаа бөгөөд улсын нэгдсэн төсвийн зарлагын 16 орчим хувийг төрийн албан хаагчдын цалин, урамшуулалд зарцуулж байна.

Гэхдээ төрийн жинхэнэ албан хаагчдад тавигдах шалгуурыг эргэн харж, засаж сайжруулах шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж, сурган төлөвшүүлэхээр заасан бөгөөд төрийн албананд анх орсон цагаас нь шат дараатай сургах, хөгжүүлэн мэргэшүүлэхээр хуульчилсан. Түүнчлэн төрийн албан хаагч нь тасралтгүй урт удаан хугацаанд төрийн албанад ажиллаж, тэр хэрээр зохих сургалтад хамрагдаж, өөрийгөө хөгжүүлж, хамт олноо манлайлж, ажил хөдөлмерөө хариуцлагатай хашсан бол шатлан дэвших зарчмын дагуу төрийн албан хаагчийн зэрэг дэвээр өсөн дэвшиж ажиллана.

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл, 2022

#### Чадахуйн зарчим

Чадахуйн зарчмыг хэрэгжүүлэн төрийн албанад хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, үр чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлан томилох тогтолцоог бэхжүүлнэ.

ЗАСАГЛАЛ

**ЧАДВАРЛАГ,  
ЁС ЗҮЙТЭЙ  
ТӨРИЙН АЛБА**

Төрийн албан хаагч ажлаас халагдсан асуудлаар 2013 онд 124, 2014 онд 116, 2015 онд 228, 2016 онд 144, 2017 онд 135 Төрийн албаны зөвлөлд гомдол ирүүлж маргаан өрнүүлж байсан бол 2013 онд 5,682, 2014 онд 7,250, 2015 онд 7,430, 2016 онд 7,705, 2017 онд 10,871 албан хаагч өөрийн хүсэлтээр чөлөөлөгджээ. Төрийн албан хаагчийн тогтвортгүй байдал нь нийгмийн баталгаа, цалин хөлс, ажлын орчин, мэргэжил ур чадвар, улс төрийн нөлөө гэх мэт олон хүчин зүйлээс хамаарч болно.

Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүй, хариуцлагатай байдал иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг. Төрийн албаны зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайландаа дурдсанаар төрийн байгууллагад нийт 2,711 ёс зүйн зөвлөл байгуулагдан ажиллаж байна. Гэвч ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, хариуцлагыг нарийн хуульчилж, зөвлөлийн гишүүдийн эрх үүрэг, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх боломж, хэм хэмжээ жишиг болохуйцаар зерчлийг хянаж, шалган шийдвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байсаар байна.

Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо тагцхүү чадахуйн зарчмыг баримтална. Аль ч улс оронд нийтийн албан тушаалтан буюу төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээнд үл өөрчлөгдөх тодорхой хэд хэдэн үндсэн заалт байдаг бөгөөд тэдгээрт авлига, хүнд суртал, хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тулгуур үзэл санаа шингэсэн байдаг. Ёс зүйн алдааны улмаас нийгэмд, нийтийн эрх ашигт учруулж болох хохирол, хөнөөлийн ур

Зураг 20. Төрийн албан хаагчийн тоо



Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл, 2022



уршгийг урьдчилан сануулах зэрэг арга замаар зөв хандлага ёс зүйг хэвшүүлнэ.

Төрийн үйлчилгээ нь төрд итгэх итгэлтэй холбогдоор ирсэн. Шударга, найдвартай төрийн үйлчилгээ нь төрд итгэх итгэлийг бэхжүүлэн, бизнест таатай орчныг бүрдүүлснээр эдийн засгийн хөгжилд чухал түлхэц болдог. Иймээс төрийн албан хаагчийн ёс зүй бол сайн засаглалын тулгуур багана болохын зэрэгцээ улс орны ирээдүй, хөгжлийн гарц болно.

Авлигад хамгийн бага өртдөг орнуудын нэг Дани улсад мэргэжлийн ёс зүйн өндөр стандартыг баримталдаг бөгөөд төрийн албан хаагчдад илүү бие даасан нөхцөл байдлыг бүрдүүлж, тэдний мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүйгээр албан тушаал ахиулдаг. Түүнчлэн төрийн албан хаагчидтай ярилцлага хийх, төсөл хэрэгжүүлэх зэргээр илүү pragmatik буюу хэрэглээний аргууд нь ёс зүйтэй орчныг бүрдүүлэх чухал хүчин зүйл болдог байна. Итали улсад захиргааны үйл явцыг энгийн төвөггүй болгож, захиргааны шийдвэр гаргалтыг ил тод болгосны зэрэгцээ төрийн албан хаагчид жил бүр орлогоо мэдүүлэх шаардлага тавьдаг. Канад, Итали, Их Британи, АНУ зэрэг улсууд төрийн албан хаагчдын санхүүгийн мэдээллийг ил тод болгох нь чухал ач холбогдолтой арга хэмжээ гэж үзжээ. ЭЗХАХБ-ын бараг бүх гишүүн орнууд дотоод хяналтын системээр дамжуулан олон нийтийн өмч хөрөнгийн менежментийг хянах, хувь хүний ёс зүйн алдаа дутагдал, системийн аливаа сул талуудыг илрүүлэх замаар урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулдаг.

Иймд төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх зорилгоор хариуцлага, урамшууллын хосолсон тогтолцоо, цогц арга хэмжээг төлөвлөсөн. Тухайлбал, төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, ажлын үр дүнгээс хамаарч шатлан дэвших зохицуулалтыг боловсронгуй болгоно. Төрийн албан хаагчийн цалин хөлс, шагнал, урамшуулал олгох, албан тушаал дэвшиүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.

Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний салшгүй чухал хэсэг болгон үнэлэх тогтолцоог хэвшүүлж, сэтгэл гарган үйлчлэх соёл бий болгоно. Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлж, ёс зүйн алдаа гаргасан төрийн удирдах албан тушаалтан сайн дураараа ажлаасаа чөлөөлөгддөг байх хандлага, ёс зүйг төлөвшүүлнэ.

Төрийн албан хаагчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих нөхцөлийг хангах ёстой. Төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд төрийн албаны сургалтын байгууллага чухал үүрэгтэй. Төрийн албан хаагчийн

МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН АЛБАНД  
2021 ОНЫ БАЙДЛААР  
НИЙТДЭЭ



**208,864**

АЛБАН ХААГЧ  
АЖИЛЛАЖ БАЙНА

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл, 2022

ЗАСАГЛАЛ

ЧАДВАРЛАГ,  
ЁС ЗҮЙТЭЙ  
ТӨРИЙН АЛБА

нэр хүндийг дээшлүүлж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах зохистой тогтолцоог бэхжүүлнэ. Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилаал, зэрэглэл, чиг үүргийн онцлогт тохирсон ўе шаттай, тасралтгүй сургалтын тогтолцоог төлөвшүүлнэ. Төрийн албаны сургалтын байгууллагын сургалт-судалгааны материаллаг орчин, хүний нөөц, технологи, арга зүйн чадавхыг бэхжүүлж, олон улсын жишигт нийцүүлэх шинэчлэл хийнэ. Төрийн албаны сургалтад мэдээллийн технологид суурилсан олон хувилбарт аргуудыг нэвтрүүлж, танхимиын сургалтаас гадна цахим болон зайн сургалтыг төрийн албаны орчин үеийн шаардлагад нийцүүлэн оновчтой ашиглах тогтолцоог бүрдүүлнэ.

Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг тухайн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүргийг харгалзан баталж хэрэгжүүлнэ. Төрийн албанад чухал үүрэгтэй төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг ч сургалтын агуулгад тусгаж өгнө. Ёс зүйн сургалтын агуулгын хувьд ихэнх орнууд төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, тэднээс хүлээгдэж буй үнэт зүйлс, ёс зүйн хэм хэмжээг ойлгуулахад оршдог. Сургалтад төрийн албаны үнэт зүйлс, тулгуур зарчмууд, ёс зүйн код, хууль дүрэм, ёс зүйн эргэлзээтэй, муухардмал байдалд орсон тохиолдолд

Зураг 21. Мэргэшсэн,  
чадварлаг, цомхон  
төрийн алба  
2021-2050 он



АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, БАТАЛГАА

Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран тогтвортой ажиллах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.



ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГА

Ёс зүйн алдаа гаргасан төрийн удирдах албан тушаалтан сайн дураараа ажлаасаас чөлөөлөгдөг байх ухамсар, соёл, хандлагыг төлөвшүүлнэ.



АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН

Хэт их бичиг цаас, тайланд тулгуурласан гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, аргачлалыг өөрчилж, төрийн албан хаагчийн бодит гүйцэтгэл, үр дүнг зөв тооцох арга зүйг нэвтрүүлнэ.



БҮТЭЦ, ОРОН ТОО

Төрийн албаны бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтооно.



шийдвэр гаргах ур чадвар, ёс зүйн зөрчлийн хэлбэрүүд, хүлээлгэх хариуцлага зэрэг мэдээллийг олгодог.

Төрийн албананд шатлан дэвших тогтолцоо бүрэн нэвтэрч, төрийн албан хаагчийн ажлын үнэлгээ, бүтээмжийн үр дүн, гүйцэтгэлд тулгуурлан цалин хөлс, шагнал урамшуулал, албан тушаал дэвших, бууруулах, чөлөөлөх асуудлыг шийддэг тогтолцоотой болно. Энэхүү тогтолцоо бүтээлч, санаачилгатай, ёс зүйтэй албан хаагчийг дэмжих хамгаалах хөшүүрэг болох учиртай. Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, илтод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлэхийн тулд чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлнэ. Мөн ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлж, төрийн албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. Төрийн албыг илүү цомхон болгож, төрийн үйлчилгээний менежментийг олон улсын түвшинд хүргэхээр зорьж байна. Ингэснээр төрийн үйлчилгээг түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, чанартай хүргэх хүний нөөцийн болон зохион байгуулалтын оновчтой арга хэрэгсэл нэвтэрч, иргэнээ дээдэлсэн төрийн үйлчилгээний чанар сайжрах юм. Иргэдийн хэрэгцээнд суурилсан, иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих юм.



ТӨРИЙН АЛБАНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТ

Цахим технологи ашиглан иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх тогтолцоог боловсронгуй болгож, шат дамжлагыг цөөлөн хүнд суртлыг арилгана.



СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнлас үл хамааран тасралтгүй сурч хөгжих тогтолцоо бүрдүүлнэ.



ЦАЛИН ХӨЛС

Төрийн албан хаагчийн цалин, хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлж, дундаж давхаргад бүрэн багтах нийгмийн баталгааг хангана.



УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төрийн албыг хүний нөөцийн нэгдсэн бодлого, удирдлагаар хангана.

ТӨРИЙН АЛБАНЫ  
ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАНД ДУРДСАНААР  
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД  
НИЙТ



2,711

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ  
БАЙГУУЛАГДАН  
АЖИЛЛАЖ БАЙНА.

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл, 2021

## ТӨРИЙН АЛБЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮЧИН ЗҮЙЛС



Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран шатлан дэвших зарчмаар төрийн албанд ажиллах нөхцөл, баталгааг бүрэн хангасан улс төрийн, хууль эрх зүйн, эдийн застийн тогтолцоог бэхжүүлж, төрийн албанд иргэнийг авах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр томилох, сургаж хөгжүүлэх бодлого, зохицуулалтыг чадахуйн зарчимд нийцүүлнэ. Төрийн албан хаагчийн цалин хөлс, шагнал, урамшуулалт олгоходо албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.

Зураг 22. Төрийн албаны тулгуур



### ХҮЧИН ЗҮЙЛС


Төрийн албыг хүчирхэг болгох хүчин зүйлсийг дээрх үндсэн чанаруудыг хэрхэн агуулж, хөгжүүлж, хэрэгжүүлж байгаагаар хэмждэг олон улсын жишиг бий.



# ТӨРИЙН АЛБАНЫ СУРГАЛТ

Төрийн албаны сургалтын байгууллагын сургалт-судалгааны материаллаг орчин, хүний нөөц, технологи, арга зүйн чадавхыг бэхжүүлж, олон улсын жишигт нийцүүлэх шинэчлэлт хийнэ. Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, чиг үүргийн онцлогт тохирсон үе шаттай, тасралтгүй сургалтын тогтолцоог төлөвшүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд төрийн албан хаагчийг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн менежментийн талаар судалгаа шинжилгээ хийх, энэ талаар бодлого боловсруулагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага ажиллана.

Зураг 23. Төрийн албаны сургалтын байгууллагын хөгжил



## ХӨГЖИХ ЗАМ

Төрийн албан хаагчийг цаг үргэлж хөгжих боломжоор хангах үндсэн арга зам бол тэдэнд зориулсан сургалт, судалгааны орчин, институцийн хөгжил, тогтолцоог бүрдүүлэх явдал болно.

ЗАСАГЛАЛ

# ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН НИЙГЭМ

**ЗОРИЛГО 5.5** Иргэний нийгэм-хувийн хэвшилт-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ.

хөгжлийн үе шат • ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**


Хүний эрхийг хангах бодлого, хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт хүргэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Нийгмийн бух харилцаанд хүний эрхийг бүрэн хангасан тогтолцоог төлөвшүүлэх үе

Хүн болж төрөн амьдарч байгаагийн хувьд өстий эрхүүдийг хүний эрх гэдэг. Хүний эрх нь үндэс угсаа, хүйс, арьсны өнгө, шашин шүтлэг, хэл, өөр бусад байдлаас шалтгаалахгүйгээр хэн бүхэнд хамаатай, угаас занагдмал билээ. Хүний хамгийн язгуур эрх болох амьд явах эрхээс эхлээд хүний зэрэгтэй амьдрахад шаардлагатай хоол хүнс, боловсрол, ажил хөдөлмөр, эрүүл мэнд, эрх чөлөө зэрэг олон асуудал хүний эрхэд багтдаг.

Хүний эрх бол хүнээс салгаж ойлгох аргагүй, амьдрахад нь шаардлагатай суурь баталгаа юм. Эдгээр нь хүн нийгэмдээ хүний зэрэгтэй амьдрах баталгаа, нөхцөлийг бүрдүүлж байдаг. Дэлхийн II дайны үед хүний эрхийн ноцтой зэрчилтэй нүүр тулсан дэлхий нийт дахин ийм байдалд хүрэхгүйн тулд НҮБ-ын Ерөнхий ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг 30 зүйлтэйгээр 1948 оны арван хоёрдугаар сарын 10-нд Францын нийслэл Парис хотноо баталсан түүхтэй. НҮБ-аас 1966 онд баталсан Иргэний, улс төрийн, эдийн засаг, нийгэм болон соёлын эрхийн олон улсын пакт болон бусад гэрээ хэлэлцээрт заасан эрхүүдийг Үндсэн хууль, бусад хуулиараа хамгаалж, хангах нь улс орнуудын хувьд нэн тэргүүний зорилт байдаг.





## ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал гэдэг хүн төрөлхтний түүхэн туршийн нийтлэг хүсэл мөрөөдөл, тэмцлийг баталгаажуулсан олон улсын эрх зүйн баримт бичгийг 1948 оны 12 дугаар сарын 10-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан. Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь “Эрх чөлөөтэй, тэгш эрхтэй байх нь хүний салшгүй эрх бөгөөд түүнээсээ хагацах ёсгүй”, “хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй” гэсэн хүний салшгүй эрхийг тунхаглан зарлаж, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнүүд болж чаджээ.

Манай улс Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан эрхүүдийг 1992 онд Үндсэн хуульд тусган баталгаажуулсан. Үндсэн хуулийн оршилд Монголын ард түмэн “...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн тунхагласан. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар иргэний нийгэм нь хувь хүнийг нийгмийн төвд тавьж, түүний үндсэн эрхийг хүндэтгэн хамгаалах үзлийг илэрхийлдэг учраас хүний үндсэн эрх бол Монголын нийгмийн хамгийн тулгуур үнэт зүйл, Үндсэн хуулийн үзэл санааны “амин сүнс”-ийн нэг билээ. Тиймээс Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” хэмээх хоёрдугаар бүлгээр зөвхөн хүний эрх, эрх чөлөөг тодорхойлно хэмээн явцууруулан ойлгож болохгүй.

Монгол Улс хүний эрхийн асуудлаар олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, тэдгээрийг хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагаагаараа дамжуулан хэрэгжүүлж, тайлagnах үүрэг хүлээсэн байдаг. Үндсэн хуулиараа баталгаажуулж, олон улсын хамтын нийтэмлэгийн өмнө амлалт өгч соёрхон баталсан гэрээ конвенцын хэрэгжилт амьдрал дээр харилцан адилгүй бөгөөд олон улсын байгууллагууд ч, хүний эрхийг хамгаалагчид ч Монгол Улсын хүний эрхийн төлөвшилд бүрэн дүүрэн хангалттай үнэлгээ өгөх боломжгүй байгааг илэрхийлдэг.

Хүний эрх, эрх чөлөөг иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөө, эдийн засаг, нийгэм, соёлын эрх, эрх чөлөө, хөгжих эрх буюу байгаль орчин, энх тайван зэрэг бүх нийтээрээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, эрх чөлөө хэмээн ангилж үздэг. Түүнээс гадна нийгмийн бусад бүлгүүдтэй харьцуулахад эрх, эрх чөлөөгөө өдлэхэд илүү их саад тогтор, бэрхшээлтэй тулгарч байдаг хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээтэй иргэд, бэлгийн цөөнх, үндэстний цөөнх зэрэг бүлгүүдийг онцгойлон авч үзэх нь бий.

“  
Үндсэн хуульд заасан  
“Хүний эрх, эрх чөлөө”  
хэмээх хоёрдугаар бүлэг  
бол манай улсын хүний  
эрхийн үндсэн суурь  
зарчим юм.  
”




**Монгол Улс** **84** ОНОО

● Эрх чөлөөний үзүүлэлт


Эрх чөлөөний нэгдсэн үзүүлэлт



Эрх чөлөөний үнэлгээ



Улс төрийн эрх



Хүний эрх, эрх чөлөө



Эх сурвалж: Freedom house, 2022

Иргэний эрхийн хүрээнд сүүлийн үед хувь хүний мэдээллийг цуглуулах, ашиглах, боловсруулах, хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, төрийн үйл ажиллагааг шүүмжлэх эрх, боломжийг үндэслэлгүйгээр хязгаарлахгүй байх, иргэд хуран цуглаж, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаан хийх эрх чөлөөг зохицуулж буй хуулийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан, хэлний цөөнх, интернэт, цахилгаанаар хангагдаагүй, алслагдмал орон нутгийн хүмүүст мэдээллийн хүртээмжийг сайжруулах, иргэний өмч эзэмшиж, өмчилж буй газрыг өөр этгээдэд давхардуулж олгохгүй байх, дайчлан авсан тохиолдолд нөхөн олговрыг шударгаар төлөх зэрэг хүний эрхийн асуудлууд анхаарал татаж байна. Мөн Жагсаал цуглааны хийх журмын тухай хуулиар “аяндаа үүссэн” цуглаан, өлсгөлөн, флаш моб зэрэг нийтийг хамарсан үзэл бодлоо илэрхийлэх шинэлэг арга хэлбэрийг зохицуулаагүй нь жагсаал цуглааны талаар эрх бүхий албан тушаалтан өөрийн үзэмжээр шийдвэр гаргах эрсдэлийг үүсгэж байгааг шүүмжилсэн байна. Иймд “засаглалын үйл ажиллагаанд иргэд эрх тэгш оролцон үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломж, чадавхыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх, нийгмийн бүлгүүд засаглалын үйл явцад тэгш оролцох боломжийг хангасан тогтолцоог бүрдүүлнэ” гэж заасан.

Хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлт (индекс)-ээр Монгол Улс сүүлийн хэдэн жилд 180 орноос 70-73 дугаарт жагсаж байна. Үүний гол шалтгаан нь Монголын хэвлэл мэдээллийн байгууллагын 10 хувь нь л өмчлөлийн талаар ил тод зарладаг, харин дийлэнх хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч эсвэл өмчлөгч нь улс төртэй холбоотой байдаг гэж үздэг учраас хэвлэл мэдээллийн хэрэгслийн ардчиллын


Хүснэгт 2. Жендерийн зөрүүтэй байдлын үзүүлэлт (индекс), Монгол Улс

	2006 он	Оноо	2020 он	Оноо
ЖЕНДЕРИЙН ЗӨРҮҮТЭЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ (индекс)	42	0.682	79	0.706
ЭДИЙН ЗАСГИЙН ОРОЛЦОО, БОЛОМЖ	21	0.704	29	0.751
БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЛТ	20	0.999	71	0.993
ЭРҮҮЛ МЭНД	1	0.980	1	0.980
УЛС ТӨРИЙН ЭРХ МЭДЭЛ	101	0.046	120	0.102

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум, 2020



Зураг 24. ТЭГШ БУС БАЙДАЛ, Жини коэффициент



төлөө хараат бусаар ажиллах байдал хязгаарлагдмал гэж үзсэнтэй холбоотой. Ардчилсан нийгмийн үндсэн үзүүлэлт болох эрх, эрх чөлөөний үзүүлэлтийг судалж эрэмбэлдэг “Freedom in the World 2022” үзүүлэлт (индекс)-ээр Монгол Улс улс төрийн эрхийн үзүүлэлтээр 40-өөс 36 оноо авсан бол иргэний эрхийн үзүүлэлтээр 60-аас 48 оноо авч нийлбэр 84 оноогоор “ЭРХ ЧӨЛӨӨТ ОРОН” ангилалд багтжээ. Ингэснээр бид Ази тивээс Япон, Өмнөд Солонгос, Тайвань, Израйл, Зүүн Тимор улсуудтай эн зэрэгцээн юм. Тиймээс хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ гэж заасан.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хүрээнд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, хүрэлцээ, цалин хөлс амьжиргаанд хүрэлцэх байдал, аж ахуй эрхлэх эдийн засаг, бизнесийн эрүүл, таатай орчны асуудал хүчтэй яригдаж байна. Төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүүлэн дэмжиж хамтран ажилласнаар нийгэм, эдийн засгийн хүрээнд тулгамдаж буй хүний эрхийн асуудлуудыг шийдвэрлэнэ. Нийгмийн бүлгүүд засаглалын үйл явцад тэгш оролцож боломжийг хангасан тогтолцоог бүрдүүлэх, хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүүлэн дэмжих, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөгжүүлнэ.

Нийгмийн тодорхой бүлгүүдийн хувьд авч үзвэл Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг Дэлхийн жендерийн зөрүүтэй байдлын үзүүлэлт (индекс)-ээр Монгол Улс 2018 онд 149 орноос 58 дугаар байранд орж байсан бол 2020 онд 79 дүгээр байр руу ухарч,

#### Жини коэффициент

Энэ нь хүн амын зардлын тэнцүү бус хуваарилалтыг илэрхийлсэн коэффициент юм. Жини коэффициент нь 0-1-ийн хооронд утга авна. Жини коэффициент нэг гэсэн утгад ойртох тутам зардлын тэнцүү биш байдал өндөр байгааг илтгэнэ. Харин энэ коэффициент нь 0-тэй тэнцүү бол зардлын хуваарилалтад ялгаа бараг байхгүй байгааг илэрхийлнэ. Тайлбар: Жил болон улирлын Жини коэффициент нь ялгаатай үзүүлэлтэд үндэслэн тооцогддог болно.

#### Чөлөөт хэвлэлийн давуу тал

- Чөлөөт хэвлэл үнэний төлөө тэмцдэг.
- Чөлөөт хэвлэл эрх мэдэлд хариуцлага тооцдог.
- Чөлөөт хэвлэл сонгогчдод мэдээлэл өгч, ардчиллыг бэхжүүлдэг.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх Монгол Улсын Үндсэн хуулиар иргэдийн үзэл санаагаа илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан.

11 байраар хойшилсон нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо хангалтгүй байгааг харуулж байна. Үүнд 2020 онд батлагдсан Сонгуулийн тухай хууль гол тээг болсон бөгөөд эмэгтэйчүүдийн оролцооны доод түвшнийг 30 хувьд хүргэх санал гарсан ч УИХ дээр дэмжигдэлгүй 20 хувиар үлдээсэн эрх зүйн орчин нөлөөлсөн юм. Монгол Улс Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийт 2011 онд батлан гаргасан бөгөөд төрийн байгуулал, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангахаар заасан тус хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд илүү анхаарах шаардлага байгаа нь судалгаагаар тогтоогдоод байна. Түүнчлэн шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, хүйсийн илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, эмзэг ядуу байдал зэргээс шалтгаалан ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлтэй хүмүүсийн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангахын тулд нийгмийн хандлагыг өөрчлөх нь эн тэргүүний чухал асуудал юм. Үндсэн хуульд заасан иргэд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах, улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх жагсаал цуглаан хийх журмыг тогтоох, уул арга





### Хүснэгт 3. Хуулийн засаглал-дэлхийн бүсээр (Зүүн Ази Номхон далааны бүс)

Улс/харьяалал	Бүсийн эрэмбэ	Нийт оноо	Нийт онооны өөрчлөлт	Өөрчлөлтийн хувь	Дэлхийн эрэмбэ	Дэлхийн эрэмбийн өөрчлөлт
Шинэ Зеланд	1/15	0.83	0.01	0.7%	7	0
Австрали	2/15	0.79	-0.01	-1.2%	13	0
Япон	3/15	0.79	0.01	0.8%	15	2 ▲
Сингапур	4/15	0.78	-0.01	-1.0%	17	3 ▼
Хонконг	5/15	0.75	-0.02	-2.0%	19	0
Өмнөд Солонгос	6/15	0.74	0.00	0.4%	20	0
Малайз	7/15	0.57	-0.01	-1.4%	54	0
Монгол	8/15	0.54	0.01	2.0%	61	3 ▲

(2021 оны байдлаар бүсийн орнуудын оноо, эрэмбэ болон өөрчлөлтийг 0-1 гэсэн оноогоор дүгнэв)

Хууль дээдлэх ёс  
Сул Хүчтэй

Эх сурвалж: World Justice project, 2022

хэмжээний үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг боловсронгуй болгох шаардлагатай.

Манай улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүн амын 3.3 орчим хувийг эзэлдэг бөгөөд Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцод нэгдэн орсноор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрхийг хамгаалах, хангахын тулд төрийн бодлого, үйл ажиллагаа, нийгмийн бүх түвшинд цогц өөрчлөлт шинэчлэл хийх, ажиллаж амьдрах саадгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээсэн. Эдгээрээс сүүлийн үед эрчимтэй шинэчлэгдэж, аливаа төрлийн шинэ бүтээн байгуулалтад хэвшиж буй дадал, чиг хандлага бол иргэний барилгын төлөвлөлтэд хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тооцож, явган хүний замд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих боломжийг бүрдүүлэх тухай стандартыг баталж, мөрдүүлж эхэлсэн явдал. Гэхдээ цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэд боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах, ажиллаж хөдөлмөрлөх, нийгмийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй авах, нийтийн тээвэр, үйлчилгээний газарт саадгүй зорчих зэргээр хүний бүхий л эрхийг адил тэгш өдлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

#### Тэгш эрх

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

## ХҮНИЙ ЭРХИЙН МЭДРЭМЖ



Хүний эрхийн Үндэсний Комисс хараат бусаар үйл ажиллагаа явуулж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж, үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэнэ. Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүүлэн дэмжих, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөгжүүлнэ. Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлж, хөгжүүлэх замаар аливаа асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй хандах соёл, хандлагыг төлөвшишүүлнэ.



### Хүний эрхийн мэдрэмжтэй соёл, хандлага


Хүний эрхийг бүхий л үйл ажиллагаа, арга хэмжээ, олон нийтийн харилцааны хэм хэмжээнд мэдрэмжтэй хандах соёл хандлагыг төлөвшишүүлж, дадал хэвшил болгоно. Хурал зөвлөгөөнд дохионы хэл хэрэглэж сурах нь үүний нэг жишээ юм.



## ХҮН БҮР ТЭГШ ЭРХТЭЙ

Төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн хяналт шалгалт, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх замаар нийгмийн бүлгүүд засаглалын үйл явцад тэгш оролцох боломжийг хангасан тогтолцоог бүрдүүлнэ. Засаглалын үйл ажиллагаанд иргэд эрх тэгш оролцон үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломж, чадавхыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. Иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, соёлын эрхийн баталгааг бүрдүүлэхдээ нийгмийн зорилтот бүлэгт эн тэргүүнд анхаарна.

Зураг 25. Хүний эрхийн үндсэн тогтолцоо



Засаглалын үйл явцад тэгш оролцох боломж

Иргэн бүр Үндсэн хуульд заасан эрхийн дагуу төрийн аливаа шийдвэрийн өмнөх хэлэлцүүлэг, ярианд оролцон мэдээлэл авах эрхээ эдлэх, үзэл бодлоо илэрхийлэх, боломж чадавхыг дээшлүүлэх нь цаг үргэлж анхаарлын төвд байх учиртай.

## ЗАСАГЛАЛ

# АВЛИГАГҮЙ ЗАСАГЛАЛ

**ЗОРИЛГО 5.6** Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.

## ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**


Авлигатай бүх нийтээр тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Авлигагүй нийгмийг цогцлоох үе


Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг авлига гэнэ.

Хүн төрөлхтөн үүссэн цагаас хойш өөрийн төрөл садан болон хэн хэндээ ашигтай байх хүсэл эрмэлзэл нь өөрөө авлигыг бий болгосон гэж үздэг бөгөөд Аристотэл, Платон нарын сэтгэгчид Ёс суртахуун, улс төрийн тогтолцоо доройтсон үед авлига цэцэглэдэг. Сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд тогтсон нэг бодлого, сайтар судалж боловсруулсан тусгайлсан хөтөлбөр, түүхэн сургамж дээр суурилсан онол практик хосолсон арга барилын заавар зөвлөгөө зэрэг боловсруулан авлигаас ангид нийгэм, засаглалын тухай төсөөллийн бус бодит зорилт дэвшиүүлэн тавих үндэслэл болж буй юм. Үүний тулд авлигатай тэмцэх стратегийн хамгийн гол арга зам нь төрийн захиргааны байгууллагууд руу чиглэдэг бөгөөд авлига үүсэх боломжийг багасгах, арилгах, үүний тулд улс төрийн албан тушаалтнуудын цалинг нэмэх, нийгмийн баталгааг хангах, хууль хүчний байгууллагын хяналтыг сайжруулах гэсэн ерөнхий шугамыг барьдаг. Түүнчлэн НҮБ-аас “Авлигын улмаас нийгмийн тогтвортой байдал болон аюулгүй байдалд үүсэж буй бэрхшээл, аюул заналхийлэл нь “Ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж байна”





Зураг 25. Монгол Улсын авлигын үзүүлэлт ба эрэмбэ



Эх сурвалж: Transparency international, 2022

гэж үзээд 2003 онд Авлигын эсрэг конвенцыг баталсан.

Харин манай улсын хувьд 1996 онд УИХ-аас Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг баталж, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, хяналт тавих, орон тооны бус Үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулсан. Үлмаар 2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталж, 2007 онд Монгол Улс түүхэндээ анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага болох Авлигатай тэмцэх газрыг байгуулсан байдаг. Авлигатай тэмцэх газар авлигачдыг олж илрүүлж, хариуцлага тооцсон тохиолдол олон. Авлигатай тэмцэх хүрээнд албан тушаалын гэмт хэргийг шалган шийдвэрлэх чадавхыг бэхжүүлж, албан хаагчдыг мэргэшүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ стандарттай болгон, төрийн албан хаагчдын орон тоог цөөлж, цахим шинэчлэлийг эрчимжүүлэх зэрэг олон зорилт дэвшиүүлсэн.

Олон улсын байгууллагуудын дүгнэснээр Монгол Улсад жижиг хэмжээний авлига аажмаар буурч байгаа боловч авлигын эсрэг хууль, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт тааруу байна. Төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгахын тулд хөрөнгө орлогын мэдүүлэг, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, хүний нөөцийн мэдээллийг ил тод болгох “Шилэн дансны хууль” зэрэг хуулиудыг батлан хэрэгжүүлж байна. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг

Авлигын үзүүлэлт  
“Транспэрэнси Интернэшнл”  
нь улс орнуудын төрийн  
байгууллагын авлигын  
түвшнийг хөндлөнгийн бие  
даасан тусгай асуулгаар  
явуулж, тэднийг харьцуулан  
0-100 оноогоор эрэмбэлдэг. 100  
гэдэг нь тухайн улс авлигагүйг  
илэрхийлнэ.

боловсронгуй болгох, авлигатай тэмцэх болон шүүх, прокурорын байгууллагын авлига, албан тушаалын гэмт хэргийг шалган шийдвэрлэх чадавхыг бэхжүүлж, албан хаагчдыг мэргэшүүлж, үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх нь чухал билээ. Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулах, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор төлөвлөсөн.

Монгол Улс авлигын талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд олон нийтийн шударга ёсны хүсэмжлэл улам бүр эрчимжиж, бодит өөрчлөлт шинэчлэлийг шаардаж байна.

Олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөхийн тулд зарим салбаруудад тухайлбал, замын цагдаа, орон нутгийн засаг захиргааны байгууллага, эмнэлэг зэрэгт чиглэсэн цогц арга хэмжээг бусад урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээтэй хамтатган хэрэгжүүлнэ. Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулна. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, стандартыг тогтоон мөрдүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулна.

Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтыг олон нийтэд ил тод болгох замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулах зорилгоор хэд хэдэн чухал хуулийг батлан хэрэгжүүлж байна. “Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг 2012 онд баталж, тус хуулийн дагуу төрийн албан хаагчид хөрөнгө, орлогын мэдүүлгээ тогтмол мэдүүлж, улмаар тэдгээр мэдүүлгийг цахимаар хэвлэн нийтэлж байна. “Шилэн дансны тухай” хуулийг 2014 онд баталсан. Тус хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Шилэн дансны нэгдсэн цахим систем”-ийг бий болгож, төсөвт

Олон нийтийн шударга ёсны хүсэл ба авлига

Дэлхийн улс орнуудын туршлагаас хараад авлигатай тэмцэх нэг гол хэрэгсэл нь олон нийтийн шударга ёсны хүсэмжлэл, авлигыг үзэн ядах соёл хэвшүүлэх явдал юм.



Зураг 26. Шилэн дансны нэгдсэн системд тавигдах мэдээлэл



албан байгууллага бүр хуулиар шаардсан мэдээллийг системд тогтмол хугацаанд оруулах үүрэг хүлээж буй. Үүнд нь аудитын байгууллага, иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэд шууд хяналт тавьж байна. Шилэн дансанд нийт 37 төрлийн мэдээлэл тавигддаг. Үүнээс 8 төрлийн мэдээлэл нь жилд 1 удаа, гурван төрлийн мэдээллийг хагас жил тутам, 11 төрлийн мэдээлэл нь улирал, сар тутам тавигддаг. Ийнхүү төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулах зорилт, арга хэмжээг цаашид илүү тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэхийг зорьж байна.

Төрийн үйлчилгээг цахимжуулснаар төрийн байгууллага, албан тушаалтны хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулахад ахиц дэвшил гарсан олон улсын сайн туршлагууд бий. Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж, иргэддээ хүргэж байгаа E-Mongolia нэгдсэн системийн үйлчилгээ энэ чиглэлд түлхэц өгөх нь дамжигүй билээ. Шударга ёсны тогтолцоог төлөвшүүлэхэд иргэд, олон нийтэд авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын нийгмийн хор аюулыг ойлгуулах, авлигаас зайлсхийх явдлыг тэдний өдөр тутмын амьдралын хэм хэмжээ, соёл болгох, нийгэмд авлигыг үл тэвчих хандлага бий болгох ёс суртахууны үндсийг бүрдүүлэх явдал чухал байна.

#### Төрийн цахим үйлчилгээ

Дэлхийн улс орнуудын төрийн байгууллага үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үйлчилгээг шуурхай хүргэх, мэдээллийг нээлттэй байлгахад мэдээллийн технологийн давуу талыг ашиглан авлигаас сэргийлэх арга хэмжээ авч байна.

## ШУДАРГА НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА



ТӨР, ТӨРИЙН  
БАЙГУУЛАГАУУД



ТӨРИЙН БУС  
БАЙГУУЛАГАУУД



ХЭВЛЭЛ  
МЭДЭЭЛЛҮҮД

### АРДЧИЛЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

Авлигын эсрэг тэмцэж, чанга  
хатуу арга хэмжээ авч, ард  
иргэдийн итгэлийг хүлээн

Ардчилал бол иргэдийн оролцоо,  
иргэний нийгэм. Иргэдийн  
оролцоог идэвхжүүлж, төр засагт  
тавих хяналтыг сайжруулах

Ардчиллын тухай мэдээлж,  
тунхаглах, хамгалан бэхжүүлж  
байх, төр засгийн ўйл ажиллагаанд  
нийтийн өмнөөс хяналт тавьж,  
зохиостой ажиллахыг шаардах

### ШУДАРГА ЁСЫГ БЭХЖҮҮЛЭХ

Хууль ёсыг чандлан сахидаг  
нийгмийг бүтээх, хуулийн  
байгуулагауд шударга, хууль  
ёсны дагуу ажиллах

Эрх тэгш ба шударга ёсыг  
шаардаж, түүний төлөө тэмцэх, төр  
засаг авлигаас ангид байх үүрэг,  
хариуцлагыг шаардах

Авлигын талаарх мэдээлэгч, шүгэл  
үлээгч, салбарын хамтран зүтгэгчээ  
хамгаалах, манлайлах

### БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ

Боловсролын салбарын төсөв,  
хөрөнгийг нэмэр, түүнийг  
шударга, ил тод зарцуулж,  
ирээдүйг сайнаар бүтээх

Боловсрол авах эрхийг шаардах,  
боловсролыг чухалчлах, нийгмийн  
соён гэгээрлийг дэмжих

Боловсролын салбарын төсөл  
хөтөлбөрүүд нээлттэй, ил тод  
байгаа эсэх, хөрөнгө санхүүжилтэд  
хяналт тавих

### Хөгжил цэцэглэлтэд манлайлах

Төрийн албан хаагчид авлига  
авахгүй байх үзэл хандлага  
төлөвшүүлэх, хариуцлагыг  
дээшлүүлэх

Адил тэгш орчин нөхцөлийн төлөө  
тэмцсэнээр улс орон хөгжинэ  
гэдгийг иргэний нийгмийн  
хамтрагчид, олон нийтэд  
ойлгуулах

Хувийн хэвшил, компаниудын  
авлигад холбогдохоос сэргийлэх,  
авлигаас ангид байгаа сайн  
туршлагыг мэдээлэн урамшуулах

### Хөгжлийг дэмжих

Авлига, хээл хахуулийг бууруулах  
замаар бүх байгууллага үйл  
ажиллагаагаа тогтвортой  
явуулах боломжийг нэмэгдүүлж,  
эдийн засгийн хөгжлийг бий  
болгох

Шударга өрсөлдөөнийг шаардах,  
авлига, хээл хахууль авдаг эрхтэн  
дархтан, байгууллагуудын эсрэг  
зогсох

Нийтийн ашиг сонирхлын төлөө  
мэргэжлийн түвшинд мэдээлэх,  
хараат бус сэтгүүлчдийн нэгдлийг  
дэмжих, хүчтэй, эрх чөлөөтэй,  
мэргэжлийн хэвлэл байх

### Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах

Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хөрөнгө санхүүжилтийг  
зориулалтын дагуу зарцуулж, үр  
ашигтай, хүртээмжтэй тогтолцоог  
бий болгох

Эрүүл мэндийн салбарын авлига,  
хор уршгийн талаарх ойлголт  
мэдлэгийг олон нийтэд түгээх,  
эрүүл мэндийн үйлчилгээ үр  
ашигтай, хүртээмжтэй байхыг  
шаардах

Эрүүл мэндийн чанар, хүртээмжийг  
талаар мэдээлэх, нийгмийн эмзэг  
булгүүдэд эмнэлгийн үйлчилгээ  
хүрч байгаа эсэхэд байнга  
анхаарах



Авлигын эсрэг тэмцлийг аль нэг дарга, улс төрийн хүчин дангаараа хийж амжилт олдоггүй. Улс нийтээрээ, салбар бүрд, иргэн бүр хийснээр шударга, эрх тэгш, авлигаас ангид төр, нийгмийг цогцлоож чаддаг. Авлигаас ангид нийгмийг бүтээх үйл хэрэгт оролцогч талуудын үүрэг, оролцоо манлайллыг зарим чиглэлд тодруулж харах нь авлигаас сэргийлэх, авлигыг үл тэвчих хандлага, соён гэгээрлийг бий болгоход тустай.



### АВЛИГААС АНГИД ХУВИЙН ХЭВШЛИЙНХЭН



### ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮД



### БҮХ ТАЛУУД

Нээлттэй, ил тод хувийн хэвшил байж, авлигыг үл тэвчих туршлагыг хэвшүүлэх

Төрийн албан хаагчдын цалин урамшуулал, нийгмийн баталгааг хангуулах чиглэлээр хамтарч ажиллах

Иргэд олон нийт мэдлэгтэй, мэдээлэлтэй байх нь эрүүл ардчиллын чухал шинж. Мэдлэгтэй, мэдээлэлтэй иргэд байвал сонгогдсон улс төрийн болон төрийн албан хаагчдад зүй ёсны шаардлага тавьдаг

Ажилтан, албан хаагчдадаа шударга орчин нөхцөл, хуулийн хүрээнд ажиллах орчин бүрдүүлэх, шаардлагатай дүрэм журмыг сахиулах

Авлигын тухай мэдээлэгчийн аюулгүй байдал, ажил хөдөлмөр, нийгмийн баталгааг хамгаалах замаар тэднийг дэмжих

Авлига, хээл хахуулийг зохих төрийн байгууллагад мэдээлнээр нийгэм, олон нийтийн сайн сайхныг хамгаалах

Боловсролын салбарыг дэмжиж, хөрөнгө оруулалт хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, түүндээ хяналт тавих

Боловсролын тогтолцооны зөв шударга байдалд хяналт тавих, нэр хүндийг нь хамгаалах

Авлигыг үл тэвчих үзэл хандлага, хүмүүжлийг ирээдүй хойч үедээ олгож, ёс суртахуун, шударга ёсыг бэхжүүлэх

Авлигаас сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, хараат бус аудит хийлгэж, авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалтнуудыг уг нөхцөлд оруулахгүй байх

Ажилтан хүн бүр өдөр тутмын ажилдаа авлигаас ангид байх дадал, хэвшлийг дэмжих, урамшуулах сурталчлах

Хийсэн болон хийх ажлынхаа төлөө авлига, хээл хахуулийн шинжтэй бэлэг сэлт, хөлс төлбөр авч, өгөхөөс татгалзах

Шударга өрсөлдөөнийг үргэлж дэмжиж, авлига өгөхөөс татгалзаж, авлигын орчин бүрдүүлэхгүй байх

Үйлдвэрчний эвлэлийн дуу хоолой, хамтын хүчийг шударга нээлттэй, ил тод нийгмийг хамгаалахад зориулах

Авлигын эсрэг үйл ажиллагаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн салшгүй нэг хэсэг байх ёстойг эрх бүхий албан тушаалтнуудад сануулж, шаардаж байх

Эрүүл мэндийн салбар дахь компаниудын үйл ажиллагааг олон улсын жишиг стандартад нийцүүлэх

Эрүүл мэндийн салбарын ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг хангах, ажлын орчин нөхцөлийг сайжруулах, авлигад өртөх эрсдэлийг бууруулах

Эрүүл мэндийн салбарын ил тод байдал, тусламж үйлчилгээний мэдээллийг нээлттэй байлгах

### ЭХ СУРВАЛЖ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын Их Хурал. (1992). Монгол Улсын Үндсэн хууль. УБ.

Монгол Улсын Их Хурал. (2022). Засгийн газрын тухай хууль. УБ.

Монгол Улсын Их Хурал. (2017). Төрийн албаны тухай хууль. УБ.

Монгол Улсын Их Хурал . (2011). Төсвийн тухай хууль. УБ.

Монгол Улсын Их Хурал. (2015). Шүүх байгуулах тухай хууль. УБ.

Монгол Улсын Их Хурал . (2014). Шилэн дансы тухай хууль. УБ.

Монгол Улсын Их Хурал. (2019). Монгол Улсын Их хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөг батлах тухай 2019 оны 106 дугаар тогтоол. УБ.

Монгол Улсын Засгийн газар. (2022). Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2016 оны 04 дүгээр тогтоол. УБ.

Монгол Улсын Засгийн газар. (2021). "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн танилцуулга. УБ.

Авлигатай тэмцэх газар. (2019). Төрийн албан хаагчийн ёсзүй гарын авлага. УБ

Цахим хөгжил, харилцаа, холбооны яам. (2021). Салбарын танилцуулга. УБ.

Төрийн албаны зөвлөл. (2022). Төрийн албаны зөвлөлийн 2021 оны тайлан. УБ.

Хамтдаа.мон цахим хуудас. (2022). Шударга нийгмийн төлөө хамтдаа. <http://khamtdaa.mn/>

Хүний эрхийн үндэсний комисс. (2022). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 20 дахь илтгэл. УБ.

Удирдлагын академи. (2019). Монгол улсын сонгуулийн тогтолцооны харьцуулсан судалгаа. УБ.

Л.Оюун-Эрдэнэ. (2021). Азийн хүлэг улс, Алсын хараа 2050. УБ.

Ц.Даваадулам. (2010). Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг.

Б.Үүрцайх. (2021). Захиргааны реформ ба Монгол Улс, КАС “Төрийн байгуулал судлал” сэтгүүл №03, 2021. УБ.

Ч.Энхбаатар, Том Гинсбург болон бусад. (2016). Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ.

Дэлхийн эдийн засгийн форум. (2020).

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://1212.mn/>

Хэвлэлийн хүрээлэн. (2021). Монголын хэвлэл мэдээлэл Өнөөдөр 2020 он. <https://pressinst.org.mn/sudalgaaj/>

Freedom House. (2022). Global Freedom Status. <https://freedomhouse.org/explore-the-map?type=fiw&year=2022>

IDEA. (022) <https://www.idea.int/data-tools/data/electoral-system-design>

OECD. (n.d.). Монгол Улс дахь авлигын эсрэг шинэttgэл.

Statista. (2020). How Voter Turnout Varies Around the World. <https://www.statista.com/chart/15996/share-of-the-voting-age-population-that-voted-in-the-most-recent-national-election/>

Transparency international. (2022). CORRUPTION PERCEPTIONS INDEX . <https://www.transparency.org/en/cpi/2021>

World Justice project. (2022). The World Justice Project Rule of Law Index. <https://worldjusticeproject.org/our-work/research-and-data/wjp-rule-law-index-2021>

### ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж	ЗД	Засаг дарга
АН	Ардчилсан нам	МАН	Монгол Ардын нам
АНУ	Америкийн Нэгдсэн Улс	МАХН	Монгол Ардын Хувьсгалт нам
АШШ	Анхан шатны шүүх	МоАН	Монголын Ардчилсан нам
БНН	Бүгд Найрамдах нам	МСДН	Монголын Социаль Демократ нам
ДЗШШ	Давж заалдах шатны шүүх	НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	УИХ	Улсын Их Хурал
ИЗНН	Иргэний Зориг Ногоон нам	ХҮН	Хөдөлмөрийн Үндэсний нам
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар	ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага